



МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

2-201 тоот, Энхтайван найрамдлын ордон, 3 дугаар хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот

Утас: 7000-0695

E-mail: mongolnaadam@mnts.ub.gov.mn

2019. 12. 27 № 271
танай _____-ны № _____-т

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭСТ**

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын
2019 оны үйл ажиллагааны тайлан болон 2018 оны
үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын мөрөөр
өгсөн зөвлөмжийн биелэлтийг тус тус хавсралтаар
хүргүүлж байна.


Хавсралт... хуудастай.

ДАРГА



Д.ХАТАНБААТАР

215030335



“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР”

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Улаанбаатар 2019 он

МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ 2019 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 19

Улаанбаатар хот

Энэхүү тайланг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/335 дугаар захирамжийн хавсралт “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ыг зэргийг тус тус үндэслэв.

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.1. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын талаар

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 20/17 тоот тогтоолоор Нийслэлийн 2019 оны төсвийг баталсан. Энэхүү төсвийн 1 дүгээр хавсралтаар Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төслийн жагсаалтын 58.1.2-ийн 10 дахь заалтад “Монгол наадам цогцолбор”-ын дэд бүтэц, их засварын ажилд 300.000.000 /гурван зуун сая/ төгрөг тусгагдсан. Энэхүү төлөвлөгөөний дагуу Нийслэлийн засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдөр А/459 тоот захирамж гарч “Монгол наадам цогцолбор”-ын дэд бүтэц, их засварын ажлын жагсаалтыг баталж уг төсөл арга хэмжээг зохион байгуулах эрхийг Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн. Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдөр ирсэн 02/578 тоот албан бичгийн дагуу “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-аас худалдан авалтын арга хэмжээг зохион байгуулагдахад шаардагдах ажлын зураг төсөв болон бусад холбогдох материалуудыг хүргүүлсэн. Нийслэлийн худалдан авах ажилгааны газраас 2019 оны 06 дугаар сарын 06-нд НХААГ/201901022/01/01 урилгын дугаартай нээлттэй тендер шалгаруулах ажлыг зохион байгуулж “Буян нэмэх интер” ХХК шалгарч 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдөр ажлаа бүрэн дуусгаж улсын комисст хүлээлгэж өгсөн. Зам дагуух борооны ус зайлуулах сувгийн ажлын хүрээнд 1400м бетон сувгийг 255 сая төгрөгийн төсвөөр, цахилгаан хангамж гэрэлтүүлгийг сайжруулах засвар шинэчлэлийн ажлын хүрээнд шинээр 910 метр кабель шугам, 3 ширхэг хувиарлах самбар хайрцагийн хамт, нийт 64 ширхэг гэрэлтүүлгийн толгойг солих ажлыг 45 сая төгрөгийн төсвөөр тус тус хийж гүйцэтгэсэн.

1.2. Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 онд эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан ажлын талаар

Үүнд: 1.4.2 Хүй долоон худагт дахь “Монгол наадам цогцолбор”-т үндэсний спортыг хөгжүүлэх, төрөлжсөн аялал жуучлал, бизнес, соёлын төв /морин уралдаан, морин аялал, бизнес үзэсгэлэнгийн төв/ барьж байгуулахад дэмжлэг үзүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын хөрөнгө

оруулалтыг татна. гэсэн заалтын дагуу Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1-45 дахь заалтын дагуу “Тал нутгийн чимээ” этник шоу-н тоглолтыг 2019 оны 9 дүгээр сарын 13-нд Хүй долоон худагт амжилттай зохион байгуулсан. Мөн жуулчдад зориулсан бэсрэг наадмыг 2019 оны 08 дугаар сард зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан боловч Нийслэлийн Засаг даргын өгсөн чиг үүргийн 2019 онд зохион байгуулагдаагүй бөгөөд Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд дахин тусгуулсан. Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1-46 дахь заалтад туссан. Морин спортын төв байгуулна гэсэн заалт нь хөрөнгө санхүүгийн эх үүсвэргүй учир Нийслэлийн Засаг даргын тамгын газрын санхүү төрийн сангийн хэлтсээс 2020 оны хөрөнгө оруулалтын жагсаалтын төлөвлөгөөнд оруулах зөвлөмжийг манайд өгсөн. /Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хавсаргав. 1-р хавсралт/

1.2.1 “Тал нутгийн чимээ- 2019” үндэсний урлагийн тоглолтыг хүй долоон худагт зохион байгуулсан тухай ажлын тайлан

Үндсэн зорилгын хүрээнд

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016- 2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.2-т заасан “Монгол наадам цогцолбор”-т үндэсний спортыг хөгжүүлэх, төрөлжсөн аялал жуулчлал, бизнес, соёлын төв болгох” заалтын хүрээнд “Хүй долоон худагт Монгол үндэсний хэв шинж маягийг агуулсан, эрийн гурван наадмын өв соёл, ёс заншлыг сурталчилсан үндэсний соёл, язгуур урлагийн тоглолтыг жил бүр уламжлал болгон тогтмол зохион байгуулан гадаад, дотоодын зочид төлөөлөгчид болон жуулчдад хүргэх ажлын хүрээнд “Тал нутгийн чимээ-2019” үндэсний урлагийн тоглолтыг 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр Хүй долоон худагт амжилттай зохион байгууллаа.

Тус урлагийн тоглолтын гол зорилго нь “Монгол наадам” үндэсний соёл, урлаг, спортын цогцолборын ирээдүйн төлөвлөлт, бүтээн байгуулалт, хэтийн зорилгыг олон нийтэд танилцуулах мөн Хүй долоон худгийн сэрүүн сайхан талд нар жаргах үеэр Монгол үндэсний язгуур урлагийн шилдэг номеруудыг Монгол улсад ажиллаж, амьдарч байгаа болон мөн аялалын журмаар ирсэн гадаадын иргэд, жуулчдад үзүүлж сонирхуулах, түүгээр дамжуулан Хүй долоон худгийн ерөнхий төлөвлөгөөг танилцуулан бизнесийн олон талт хамтрагчтай болох явдал юм.

“Тал нутгийн чимээ- 2019” үндэсний язгуур урлагийн тоглолт нийт 3 цаг үргэлжилсэн бөгөөд тоглолтод тив дэлхийд уран бүтээлээрээ танил болсон Жонон хамтлаг, үндэсний язгуур урлагийн шилдэг номерууд болон улсын циркийн уран нугаралтын үзүүлбэр, Монголын үндэсний загварын үзүүлбэр, үндэсний тоглоом наадгай, монгол уран бичлэг буюу каллиграф бичгийг сурталчлах үзүүлбэр зэргийг тус тус багтааж өгсөн юм.



Тоглолтын асарын гадна болон дотор харагдах байдал

Хамрах хүрээний хувьд

2019 оны 09 дүгээр сарын 13-ны Баасан гаригт Хүй долоон худгийн соёл, урлагийн талбайд зохион байгуулагдсан тус урлагийн тоглолтыг Хорват, Турк, Хятад, Герман, Япон, Солонгос зэрэг 6 орны 186 гаруй гадаадын иргэд, жуулчид ирж үзэж сонирхсон юм. Тус тоглолтын дэлгэрэнгүй мэдээллийг НАЖГ, Монголын аялал жуулчлалын холбоонд хүргүүлэн мөн өөрсдийн нөөц бололцоог дайчлан нийт 86 гаруй жуулчлалын тур оператор байгууллагуудруу тоглолтын танилцуулга бүхий и-мэйл илгээн, утсаар холбогдон жуулчин татаж ажиллаа. Тоглолтод хүрэлцэн ирсэн жуулчдыг Дашчойлин хийд болон Улаанбаатар зочид буудлын дэргэдээс жуулчны автобусаар тээвэрлэн Хүй долоон худагт авчирсан бөгөөд оройны 20:30 минутад нийт зочдыг нэгдсэн маршрутаар Улаанбаатар хотруу хөдөлсөн.



Жуулчид автобусаар Хүй долоон худагт хүрэлцэн ирж буй нь

Ерөнхий зохион байгуулалт, тоглолтын хөтөлбөр, мэдээлэл сурталчилгааны хувьд

“Тал нутгийн чимээ-2019” үндэсний урлагийн тоглолтонд Улаанбаатар чуулгын уран бүтээлчид болон Үндэсний циркийн уран нугараачид, үндэсний хөгжмийн Жонон хамтлаг, МУЭ-ын гишүүн, зураач СТА Цэнд-Очир, ДиЖэй Агваан, Баянгол дүүргийн хүндэт иргэн 74 настай буурай Зулзагаа гуай нар оролцон Монгол үндэсний өв соёл, язгуур урлагийн гайхамшигийг хүрэлцэн ирсэн жуулчдад танилцуулж ажиллаа.



“Тал нутгийн чимээ- 2019” үндэсний урлагийн тоглолт нээж буй нь

Улаанбаатар чуулгын уран бүтээлчид цамын бүжиг, уртын дуу, морин хуурын тоглолт, үндэсний бүжиг, хөгжмийн шилдэг номерууд, монгол ардын дуу, уртын дуу, гоцлол бүжиг, хөөмийн болон нумт хуурийн номеруудаа тус тус үзүүлж сонирхуулсан бол МУЭ-ийн гишүүн, СТА Цэнд-Аюуш Монгол уран бичлэг болох каллиграф бичгээр “Монгол наадам цогцолбор” гэдэг үгийг бичиж сонирхуулан ирсэн жуулчдын захиалсан нэрийг бичиж өгч үндэсний уран бичлэгээ үзүүлсэн. БГД-ийн хүндэт иргэн Н.Зулзагаа гуай өөрийн гараар урласан Монгол үндэсний оньсон тоглоом болох “Уран бэрийн нүүдэл” тоглоомын түүх болон ач холбогдлыг ирсэн жуулчдад тайлбарлан танилцуулж байлаа.



. Каллиграф бичгийн үзүүлбэр танилцуулж буй нь



Монгол үндэсний оньсон тоглоом “Уран бэрийн нүүдэл” тоглоом танилуулж буй байдал



Үзэгчид оньсон тоглоом тоглож буй байдал

Хүрэлцэн ирсэн жуулчдаас тайзнаа урин гаргаж оньсон тоглоомоороо тоглуулан хамгийн хурдан сурч, эвлүүлсэн жуулчдад гарын бэлэг болох үндэсний тоглоом болон монгол уран бичлэгээр нэрээ бичүүлэх эрх олгосон нь зочдод ихээхэн өндөр сэтгэгдэл төрүүлж чадсан юм



Мөн дэлхийд гайхагдах уран нугаралтын үзүүлбэрийг УБ циркийн жүжигчид болох н.Наран, н.Цэнддаваа нар үзүүлж сонирхуулсан бөгөөд нийт ирсэн зочдын сэтгэл хөдлөн талархалаа илэрхийлж байсан.



Уран нугаралт үзэж сонирхож буй жуулчид

Үүний дараагаар “Эра модель энтернэйшнл” агентлагийн загвар өмсөгчид Монгол үндэсний дээл хувцас болох Халх, Буриад, Баяд, Захчин ардын дээл хувцасыг танилцуулан үзүүлбэр үзүүлсэн ба тоглолтын төгсгөлд Монголын үндэсний хөгжмийн хамтлаг болох “Жонон” хамтлаг 30 минутын турш үндэсний хөгжмийн тоглолтоо жуулчдад үзүүлж сонирхуулсан юм. Тоглолтын төгсгөлд ДиЖэй Агваан хүрэлцэн ирж хөгжмийн сет-ээ жуулчдад сонирхуулсан бөгөөд жуулчид Хүй долоон худгийн задгай талбайд хөгжмийн аянд бүжиглэж сэтгэл өндөр байлаа.



Загвар өмсөгчид, Үндэсний хөгжмийн “Жонон” хамтлаг уран бүтээлээ сонирхуулж буй нь

Талбайн тохижилтын хувьд

“Тал нутгийн чимээ- 2019” үндэсний урлагийн тоглолт 9 дүгээр сард зохион байгуулагдаж байгаа гэдэг утгаараа ирсэн зочдоо дааруулахгүй байлгаж тав тухыг нь хангах үүднээс 350м2 хэмжээтэй нийт 300 хүний багтаамжтай зориулалтын асар түрээслэн дотор нь ширээ, сандал байрлуулан тохижуулсан бөгөөд мөн ирсэн жуулчдыг уйдаахгүй байлгах үүднээс 30 минутын бүжгийн сет явуулахаар төлөвлөн асартаа тайзны гэрлүүд угсарч байрлуулж тохижуулсан юм. Тоглолтын асарын гадна талд 4х8-ийн хэмжээтэй хана /Backdrop/ босгон тоглолтын нэрийг хэвлэн тогтоож ханын хоёр талд тоглолтын нэр бүхий тугыг байршуулан тохижуулсан бөгөөд ирсэн зочид тус хананы өмнө Монгол үндэсний дээлтэй загвар өмсөгчидтэй гэрэл зурагаа авахуулж байсан юм. Мөн тоглолтын асарт 3х4-ийн хэмжээтэй лед дэлгэц угсран байрлуулж “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын танилцуулга

шторкыг ирсэн жуулчдад монгол, англи орчуулгатайгаар үзүүлж сонирхуулсан юм. Тоглолтод ирсэн бүх жуулчдыг халуун виноогоор угтан асарт оруулж мөн мэргэжлийн байгууллагатай хамтран халуун, хүйтэн уух зүйлс, хөнгөн зууш, десерт, амттанаар үнэ төлбөргүй үйлчилсэн.



Зочдын угтах хэсэг буюу халуун хүйтэн уух зүйлс, зуушаар үйлчлүүлж буй байдал

Үр дүн

Монголын “Үндэсний язгуур урлаг”-ийг гаднын зочид төлөөлөгч, жуулчдад сурталчилан таниулах, Хүй долоон худагт зуны улиралд жуулчин татах зорилготойгоор “Тал нутгийн чимээ-2019” үндэсний урлагийн тоглолт ийнхүү анх удаагаа Хүй долоон худагт амжилттай зохион байгууллаа. Тоглолтын ерөнхий төлөвлөгөө болон хөтөлбөр батлагдсан удирдамжийн дагуу явагдаж ирсэн жуулчид сэтгэл өндөр буцлаа. Мөн анх удаа зохион байгуулагдсан тус тоглолтын онцлог нь үндэсний хөгжим, соёл урлаг, бичиг соёл, үндэсний тоглоом, наадгай зэргийг жуулчдад сурталчилах байсан бөгөөд эдгээр бүх үзүүлбэрүүдийг тус тоглолтод багтааж өгсөнөөрөө үндэсний хэмээх тодотголоо илүү хадгалан сонирхолтой, үзүүштэй болж чадлаа. Энэ жилийн 6, 7, 8-р саруудад Хүй долоон захиалгат арга хэмжээнүүд зохион байгуулагдаж байсны улмаас “Тал нутгийн чимээ” тоглолтыг ийнхүү 9 дүгээр сарын эхэнд зохион байгуулсан бөгөөд цаг агаарын хувьд оройн 19:00 цагаас хойш бага зэргийн сэрүүвтэр болж байсныг энд дурдах хэрэгтэй болов уу.

Тоглолтын дараагаар байгууллагын даргын дэргэдэх зөвлөл уг арга хэмжээг дүгнэн хэлэлцэж байгууллагын жилийн үндсэн үйл ажиллагааны нэг болох тус тоглолтын цар хүрээг өргөжүүлэн, цаг хугацааны хувьд нарийн төлөвлөн жил бүрийн 7 дугаар сард уламжлал болгон зохион байгуулж байхаар төлөвлөлөө. Мөн 2020 онд “Тал нутгийн чимээ” тоглолт зохион байгуулах төлөвлөгөөт хугацааг гаргаж Нийслэлийн аялал жуулчлалын газар болон Монголын аялал жуулчлалын холбоонд урьдчилан мэдэгдэж МУ-ын жилийн аялал жуулчлалын төлөвлөгөөнд тусгаж, жуулчдыг олноор хамруулан ажиллахаар төлөвлөлөө.

ХОЁР. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН

2.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ 2019 оны эхний хагас жилийн байдлаар Улсын Их хурлын 1 тогтоол, Засгийн газрын 5 тогтоол, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн 2 тогтоолыг тус тус үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

2.1.1 Улсын Их хурлын тогтоол

Улсын Их хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ний өдрийн “ Авлигатай

Нийтийн албан тушаалтныг авлигын эсрэг соён гэгээрүүлэх, чадавхжуулах замаар авлигаас урьдчилан сэргийлэх зорилготой сургалтыг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын албаны дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн, Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Х.Хашбаатар, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Т.Баярхүү, Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга, ахлах комиссар Ц.Цэцэгдэлгэрэх, Судалгаа шинжилгээний албаны дарга, ахлах комиссар Ц.Шинэбаяр, Мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөгч, ахлах комиссар Ч.Жаргалбаатар нар “Авлигатай тэмцэх сайн туршлага”, “Ашиг сонирхлын зөрчил”, “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа”, “Мэдүүлэг гаргахад анхаарах асуудал”, “Авлигын шалтгаан, хор хөнөөл”, “Авлигын гэмт хэрэг-шинэ зохицуулалт” зэрэг сэдвүүдээр тус тус сургалт хийж арга зүйн шинэ мэдлэг, мэдээллийг өглөө.

2.1.2 Монгол Улсын засгийн газрын тогтоол

2.1.2. Монгол Улсын засгийн газрын 2016 оны 225 дугаар тогтоол

Монгол Улсын ЗГ-ын 2015 оны 11-р сарын 23-ны өдрийн 456-р тогтоолоор “Монгол наадам цогцолбор”-ын хэрэгцээнд зориулан нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт хамаарах 551га, Төв аймгийн Аргалант сумын нутаг дэвсгэрт хамаарах 12,031га буюу нийт 12,582 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах шийдвэр гарч, хилийн цэсийг тогтоож өгсөн хэдий ч ЗГ-ын тогтоолоос өмнө болон хойно газар олголт хийгдсэнээс газрын давхцлын асуудал үүсэж, тус газар нь дүрмээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдал үүссэн.

Улмаар нийслэлийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/890 дугаар захирамжаар “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-т олгогдсон улсын тусгай хэрэгцээний газрын давхцалын асуудлыг шийдвэрлэх талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөрөөр ахлуулсан ажлын хэсэг байгуулагдаж ажиллаж 2019 онд тусгай хэрэгцээний газрын хэмжээ хилийн заагт өөрчлөлт орсны улмаас Төв аймгийн Аргалант сумын нутаг дэвсгэрт хамаарах 12,031 га газраас 2006 га газрыг улсын тусгай хэрэгцээний газраас чөлөөлж, шинээр 449 га газрыг нэмэх байдлаар нийт 10,474 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 06 дугаар

сарын 13-ны өдрийн 5 дугаар тогтоолоор батлуулж Нийслэлийн СХД-ийн нутаг дэвсгэрт хамаарах газрын асуудлыг НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр НИТХ-аар оруулах төсөл өргөн барьж хэлэлцүүлэн хилийн цэсийн өөрчлөлтийг барилга хот байгуулалтын яаманд хүргүүлэхээр болсон.

2.1.2.2 Монгол Улсын засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 01 дүгээр албан даалгавар, Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2018 оны 03 тоот албан даалгавар, Байгууллагын даргын 2018 оны А/48 тоот тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор 6 ажлыг төлөвлөсөн ба хэрэгжилт 70 хувийн биелэлттэй байна. Байгууллага, иргэдээс ирүүлсэн (erp.ulaanbaatar.mn цахим хуудас болон цаасаар) өргөдөл, гомдол санал хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэж байх, ажилчдын цаг ашиглалтыг хурууны хээний хяналтыг сайжруулах, ажлын цагийг бүрэн, үр дүнтэй ашиглах, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох зэрэг ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. Түүнчлэн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталж ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар болон шалт, хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хориглосон заалтуудыг тус тус нэмж тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ ажил үүрэг гүйцэтгэсэн сахиул Д.Хүрэлбатад газрын даргын Б/51 тоот тушаалаар сануулах, ажлын байран дээр архидан согтуурч танхайрсан сантехникч Г.Тэгшээд Б/50 тоот тушаалаар сануулах, мөн согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ ажил үүргээ гүйцэтгэсэн тохижилт үйлчилгээний ажилтан Ц.Ганхуягт Б/131 тоот тушаалаар сануулах шийтгэл оногдуулан 1 сарын хугацаанд үндсэн цалинг 20 хувь, мөн ажлын байранд дээр архидан согтуурч танхайрсан тохижилт үйлчилгээний ажилтан Г.Ганхуягийг газрын даргын Б/51 сануулах шийтгэл оногдуулан үндсэн цалинг 20 хувиар тус тус бууруулж, хариуцлага тооцон ажиллаж байна.

2.1.2.3 Монгол Улсын засгийн газрын 2019 оны 23 дугаар тогтоол

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн “Иргэн төвтэй үйлчилгээний жил болгон зарлах тухай” 23 дугаар тогтоолын төлөвлөгөөний хавсралтад “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын хариуцах ажил байхгүй бөгөөд Нийслэлээс 2019 оныг “Иргэдийн оролцоотой хөгжлийн жил” болгон зарласан бөгөөд энэ хүрээнд 2 ажлыг гүйцэтгэн ажиллаа. Зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын төрийн захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.

2.1.2.4 Монгол Улсын засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоол

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн “Дүрэм батлах тухай” 33 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт “Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай” гэж заасан ба Энэ тогтоолын дагуу байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд холбогдох заалтуудыг оруулан Байгууллагын даргын 2019 оны А/14 тоот тушаалаар байгууллагын ёс зүйн зөвлөлийг байгуулан хавсралтаар түүний ажиллах журмыг 5 бүлэг 17 зүйлтэйгээр батлан мөрдүүлэн ажиллаж байна.

2.1.2.5 Монгол Улсын засгийн газрын 2019 оны 59 дүгээр тогтоол

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-т 2019 онд худалдан авалт төлөвлөгдөөгүй байна. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ний өдрийн “Эх оронч худалдан авалтын жил” болгон зарлах тухай 59 дүгээр тогтоолын дагуу байгууллагын өдөр тутмын хэрэгцээт бараа материалыг дотоодод үйлдвэрлэсэн аж ахуй нэгжийн бараа бүтээгдэхүүнээс сонгон авч байна. Энэ ажлын хүрээнд ажилчдын хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлыг хангах үүднээс “Ариза интернэйшнэл” ХХК-д үйлдвэрлэсэн ажлын хувцасыг 1.450.000 төгрөгөөр худалдан авч дотоодын аж ахуй нэгжийг дэмжин ажиллаж байна.

2.1.3 Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 99 дүгээр тогтоолоор баталсан “Монгол наадам цогцолбор” төслийн нэгж, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг байгуулах, 2014 оны 127 дугаар тогтоолоор баталсан “Монгол наадам цогцолборт олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахад мөрдөх журам”, 2018 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолуудыг тус тус үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

/Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн хавсаргав. 2-р хавсралт/

2.2 Иргэдийн оролцоотой хөгжлийн жилийн хүрээнд

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаас 2019 оныг “Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил” болгон зарласан бөгөөд энэхүү жилийн хүрээнд “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-аас “Монгол наадам цогцолбор” төслийн ерөнхий төлөвлөгөө, хэтийн зорилго, алсын харааг тодорхойлох зорилгоор байгууллагын дэргэдэх Орон тооны бус бодлогын зөвлөлийн гишүүд болон үндэсний спортын зүтгэлтэн, эрдэмтэн судлаачдын төлөөллүүдийг хамруулсан хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Мөн ҮИБН болон Хүй долоон худаг дахь хурдан морины уралдааны зохион байгуулалт, тохижилтыг сайжруулах зорилгоор наадмын өдрүүдэд 1000 иргэнээс судалгаа авч үр дүнг ҮИБН-ын Тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний салбар хороо болон Хурдан морины салбар хороонд тус тус хүргүүлэн ажиллахаар судалгааны асуулгыг боловсруулаад байна. Нийслэлийн 380 жилийн ойн хүрээнд байгууллага өөрийн дотоод нөөц бололцоог ашиглан Хүй долоон худаг дахь оффисийг камержуулж, Монгол наадам гэр баазад хүүхдийн тоглоомын талбай тохижуулан, ажиллаж байна.

2.2.1 ҮИБН-ын тохижилт, үйлчилгээний талаар иргэдээс авсан сэтгэл ханамжийн судалгааны тайлан

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны хөтөлбөрийн заалтын дагуу “Монгол наадам цогцолборын” ОНӨТҮГ-ын 2019 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний 23.3-т Хүй долоон худаг дахь хурдан морины уралдааны зохион байгуулалт, тохижилтыг сайжруулах зорилгоор наадмын өдрүүдэд 1000 иргэнээс судалгаа авч үр дүнг ҮИБН-ын тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний салбар хороо болон Хурдан морины салбар хороонд тус тус хүргүүлэн ажиллана гэсэн ажлыг төлөвлөгөөнд тусгасан. Тус төлөвлөгөөт ажлын дагуу 2019 оны ҮИБН-ын өдрүүдээр буюу 07 дугаар сарын 10, 11, 12, 13-ны өдрүүдэд Хүй долоон худагт цугларсан наадамчин нийт 1000 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан.

Судалгаа нь ерөнхий мэдээллийн гурав, үндсэн асуулгын ес нийт 12 асуулттай 2-5 сонголт бүхий хариулттай байсан. Энэ жилийн ҮИБН-аар Хүй долоон худагт 45 мянга орчим хүн хүрэлцэн ирсэн бөгөөд нийт 1000 иргэнээс судалгаа авснаас 836 судалгаа хүчинтэй тоологдлоо. Судалгааны асуултууд болон хариултыг хувьчилсан хэлбэрээр танилцуулбал:

“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ

СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА /2019 он/

Хүй долоон худаг дахь Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааны тохиолт, зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор наадамчдаас судалгаа авч үр дүнг ҮИБН-ын тохжилт, зөвсөр, худалдаа үйлчилгээний салбар хороонд хүргүүлэн ажиллана.

А. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Таны нэс	2. Таны хүйс	3. Таны боловсрол
1. 10-25	1. Эр	1. Бүрэн дунд
2. 26-35	2. Эм	2. Тусгай мэргэжлийн дунд
3. 36-45		3. Дунд
4. 46-50		4. Бусад

Б. АСУУЛТУУД

1. Та Хүй долоон худагт боловч бөөр наадмын хөтөлбөр, арга хэмжээний талаар хаанаас мэдээлэл авдаг вэ?

а. Фейсбүүн, цахим хаягаар	б. Тэр бүл	в. Майз нөхдөөс
г. Төлөвнэ, радио	д. Сонин сэтгүүл	е. Аич наадамгүй

2. ҮИБН-ын Хурдан морины салбар хорооны үйл ажиллагааны зохион байгуулалтанд хэр сэтгэл хангалуун байдаг вэ?

а. Хурдан морины салбар хороо	сэйн	дунд	муу
б. Замын цагдаагийн алба	сэйн	дунд	муу
в. Хэв журмын цагдаагийн алба	сэйн	дунд	муу
г. Мэргэжлийн кинэлтын газар	сэйн	дунд	муу
д. Онцгой байдлын хэлтэс	сэйн	дунд	муу
е. Түргэн тусламж	сэйн	дунд	муу

3. Танд үйлчилж буй аживаабуусны хуралцаа, үйлчилгээ /жолооч нарын хариуцааны соёл, ажиллах цагийн хуваарь, цэвэрлэгээ үйлчилгээ/ ямар байна вэ?

Хуралцаа	а. Хангалттай	б. Хангалтгүй	в. Муу
Хариуцааны соёл	а. Сайн	б. Дунд зэрэг	в. Муу
Цагийн хуваарь	а. Хангалттай	б. Хангалтгүй	в. Муу
Цэвэрлэгээ, үйлчилгээ	а. Сайн	б. Дунд зэрэг	в. Муу

4. Хүй долоон худгийн авто машины зогсооглын хүртээмж ямар байдаг вэ?

а. Сайн	б. Дунд	в. Хангалтгүй
---------	---------	---------------

5. ҮИБН-ын Хүй долоон худгийн морь барианы газрын үзэгчдийн сандтын хуралцаа хангалттай байдаг уу?

а. Хангалттай сайн	б. Хуралцаагүй	в. Боломжийн
--------------------	----------------	--------------

6. ҮИБН-аар кооп, хүнсний худалдаа үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг ААН-д олгодог болсноор наадмын талбайд борлуулагддаг хоолны амт, чанар, ариун цэвэр, үйлчилгээнд дэвшилт гарсан уу?

а. Тийм	б. Үгүй
---------	---------

7. “Монгол наадам үндэсний спорт цогцолбор”-ын талаар та ямар мэдээлэлтэй байна вэ?

а. Зөвхөн наадам зохион байгуулдаг	б. Цэнгэлдэх хүрээлэн барина
в. Эрийн 3 наадмын төв цогцолбор болно	г. Аллал жуулчлалын төв цогцолбор болно
д. Мэдээлэлгүй	

8. Та хүй долоон худагт болдог ҮИБН-ын хурдан морины уралдааныг ямар хэлбэрээр үзэх хүсэлтэй байдаг вэ?

а. Төлөвнэ	б. Тав тухтай орчин үеийн морь барианы задгай өсөрт
в. Онж үзэх	г. Үзэх шавардлаггүй

9. Та ҮИБН-ын хурдан морь, бөх, сур, шагзайн хэрвэл Хүй долоо худагт нэг дор уламжлал болгон зохион байгуулахын тулд ерөнхий төлөвлөгөөний дагуу бүтээн байгуулалт хийхийг дэмжих байна уу?

а. Маш чухал	б. Дэмжих байна	в. Шавардлаггүй
--------------	-----------------	-----------------

10. Хүй долоо худагт ҮИБН-аар иргэдэд үйлчилж буй нийтийн бие засах газруудын хуралцаа, үйлчилгээ /үйлчилгээний хариуцааны соёл, ажиллах цагийн хуваарь, цэвэрлэгээ үйлчилгээ/ ямар байна вэ?

Хуралцаа	а. Хуралцаагүй	б. Сайн	в. Дунд
Хариуцааны соёл	а. Маш сайн	б. Хангалтгүй	в. Дунд
Цагийн хуваарь	а. Хангалттай	б. Сайн	в. Дунд
Цэвэрлэгээ, үйлчилгээ	а. Маш сайн	б. Сайн	в. Дунд

Судалгаанд оролцсон танд баярлалаа.
ТА САЙХАН НААДААРЫ

/Судалгааны эх хувь/



Тус төлөвлөгөөт ажлын дагуу 2019 оны ҮИБН-ын өдрүүдээр буюу 07 дугаар сарын 10, 11, 12, 13-ны өдрүүдэд Хүй долоон худагт цугларсан наадамчин олноос судалгаа авч буй байдал

Дүгнэлт:

Судалгааны дүнг авч үзвэл:

Насны байдлаар: 286 хүн буюу 28,6% нь 36-45 насныхан идэвхтэй хамрагдсан байна. **Үүнээс хүйсийн байдлаар:** 458 буюу 65,8% нь эмэгтэйчүүд идэвхтэй судалгаанд оролцсон байна.

Боловсролын байдлаар: 400 буюу 52% нь дээд боловсролтой байна.

- Хүй долоон худагт болдог баяр наадмын хөтөлбөр, арга хэмжээний талаар хаанаас мэдээлэл авдаг вэ гэсэн асуултанд нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 37% буюу 268 нь фейсбүүкээс авдаг хэмээн хариулсныг харахад бидэнд мэдээлэл өгдөг хамгийн ойрын суваг бол цахим хуудас юм.

ҮИБН-ын өдрүүдээр Хүй долоон худагт ажилласан хурдан морины салбар хороо болон бусад төрийн үйлчилгээнүүдэд дараах үнэлэлтүүдийг өгсөн байна. Үүнд: Хурдан морины салбар хороог 67% нь дунд гэсэн үнэлэлт өгсөн.

- Хэв журмын цагдаагийн алба 70% нь сайн гэсэн үнэлэлт өгсөн.
- Замын цагдаагийн алба 65% нь сайн үнэлгээ
- Мэргэжлийн хяналтын газар 65% нь дунд гэсэн үнэлгээ өгсөн
- Онцгой байдлын хэлтэс 77% нь сайн
- Түргэн тусламж 72% нь сайн ажилласан гэсэн үнэлэлт өгсөн байна.
- Хурдан морины салбар хороо болон Мэргэжлийн хяналтын газрын ажлыг наадамчин олны 70% нь сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

Экоавтобусны хүрэлцээ, жолооч нарын харилцааны соёлын үнэлгээ:

- Экоавтобусын хүрэлцээг 87,8% хангалтгүй гэсэн одоо үйлчилж байгаа экоавтобуснууд ҮИБН-ын өдрүүдэд ачаалал ихэссэн байдаг тул хүрэлцдэггүй. Иймд экоавтобусыг нэмж авах шаардлагатай гэж үзэж байна.
- Цэвэрлэгээ үйлчилгээ 48,7% нь дунд гэсэн цаашид цэвэрлэгээ, үйлчилгээнд анхаарах хэрэгтэй байна.

Хүй долоон худгийн авто машины зогсоолын хүртээмжийн хувьд:

305 хүн буюу 39,4% нь баяр наадмын өдрүүдэд хангалтгүй байдаг бөгөөд зогсоолыг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн хариулт өгсөн байна.

Морь барианы газрын үзэгчдийн сандлын хүрэлцээний хувьд:

477 хүн буюу 53,8% нь хүрэлцдэггүй хэмээн хариулсан байна. Иймд Хүй долоон худгийн морь барианы газарт орчин үеийн морин уралдааны задгай асар барих нь нэн тэргүүнд шаардлагатай байгаа юм.

ҮИБН-аар хоол хүнсний худалдааны чанар, амт, ариун цэвэр, үйлчилгээнд дэвшилт гарсан уу гэсэн асуултад:

Хоол хүнсний худалдаа, үйлчилгээ сайжирсан буюу дэвшилт гарсан гэсэн хариултыг нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 498 буюу 57,8% нь өгсөн байна.

“Монгол наадам үндэсний спорт цогцолбор”-ын талаар ямар мэдээлэлтэй байдаг вэ гэсэн асуултад:

265 буюу 35,8% нь “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ байгууллагыг ямар үйл ажиллагаа явуулдаг талаар огт мэдээлэлгүй байдаг. Иймд байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд таниулах ажлыг цаашид идэвхтэй явуулах хэрэгтэй гэсэн дүгнэж байна.

ҮИБН-ын хурдан морины уралдааныг ямар хэлбэрээр үзэх хүсэлтэй байдаг вэ гэсэн асуултад:

Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 499 буюу 64,7% нь тав тухтай орчин үеийн задгай асарт үзэх хүсэлтэй байна хэмээн хариулсан байгаагаас харахад наадамчин олон үндэсний эрийн гурван наадмын нэг болох хурдан морины уралдааныг орчин үеийн задгай асарт үзэхийг ихээр дэмжиж байгаа нь харагдаж байна.

ҮИБН-ын эрийн 3 наадмыг Хүй долоон худагт нэг дор уламжлал болгон зохион байгуулах байдлаар ерөнхий төлөвлөгөөний дагуу бүтээн байгуулалт хийхийг дэмжиж байна уу гэсэн асуултад:

Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 468 хүн буюу 57,8% нь маш чухал гэсэн хариултыг дугуйлсан бөгөөд ҮИБН буюу эрийн гурван наадмыг Хүй долоо худагт нэг дор зохион байгуулж ерөнхий төлөвлөгөөний дагуу бүтээн байгуулалт хийх нь маш зөв юмаа гэж дүгнэж байна.

Хүй долоон худагт ҮИБН-аар иргэдэд үйлчилж буй нийтийн бие засах газруудын хүрэлцээ, үйлчилгээ /үйлчлэгчийн харилцааны соёл, ажиллах цагийн хуваарь, цэвэрлэгээ үйлчилгээ ямар байна вэ гэсэн асуултад

Судалгаанд хамрагдсан иргэдийн 450 буюу 56,7% нь дунд гэсэн үнэлгээ өгсөн байгаа нь Нийтийн бие засах газруудын цэвэрлэгээ үйлчилгээ дунд шатанд явж байгаа бөгөөд нэмж сайжруулах шаардлагатай байна гэж үзэж байна.

Нийт 12 асуулга бүхий судалгааны дүгнэлтээс харахад ҮИБН-ын Хүй долоон худагт зохион байгуулагддаг хурдан морины уралдаан нь ерөнхий зохион байгуулалт, талбайн тохижилтуудын хувьд наадамчин олны сэтгэлд төдийлөн хүрдэггүй ч илүү хөгжүүлэн тохижуулах хүсэл эрмэлзэл дүүрэн байдаг нь судалгаанд хамрагдаж буй иргэдийн идэвхээс харагдаж байлаа.

2.2.2 “Монгол наадам цогцолборын өнөөгийн байдал, цаашдын хөгжил” хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

2019 оныг “Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил” болгон зарласан ажлын хүрээнд “Монгол наадам цогцолбор” төслийн ерөнхий төлөвлөгөө, хэтийн зорилго, алсын харааг тодорхойлох зорилгоор байгууллагын дэргэдэх орон тооны бус бодлогын зөвлөлийн гишүүд, төрийн болон төрийн бус үндэсний спортын төлөөллүүдийг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулж ажлын үр дүнг байгууллагын үйл ажиллагаанд тусгаж ажиллан гэсэн заалтын дагуу 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Хангарьд ордны 14 давхарт “Аялал жуучлалын төв” ТӨҮГ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир спортын газар,

Нийслэлийн соёл урлагийн газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн ОНӨАТҮГ, Улаанбаатар хөгжлийн корпораци ХК, “Монголын Морин спортын уяачдын холбоо” ТББ, “Морин спортын холбоо” ТББ, “Монголын үндэсний харваачдын холбоо” ТББ, “Монголын шагайн харвааны холбоо” ТББ, “Үндэсний бөхийн холбоо” ТББ, “Усан тэлмэн” жороо судлалын академи ТББ, “Монголын аялал жуулчлалын холбоо” ТББ, “Монголын хөнгөн атлетикийн холбоо” ТББ, “Монголын соёл, аялал жуулчлалын холбоо” ТББ, “Урлагийн залуучуудын холбоо” ТББ, Спортын төв сургууль зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулан амжилттай зохион байгууллаа.



Тус хэлэлцүүлэгт Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ын дарга Д.Хатанбаатар Монгол наадам цогцолборын танилцуулга, өнөөгийн байдал, улсын тусгай хэрэгцээний газрын асуудал, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, 2020-2040 он хүртэлх Хүй долоон худаг дахь бүтээн байгуулалт, эрийн гурван наадмыг нэг доор зохион байгуулах хэрэгцээ шаардлага, ач холбогдлын талаар танилцуулга хийж, Монгол наадам цогцолборын орон тоо бус зөвлөхүүд, төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллүүд монгол оронд аялал жуулчлалыг хэрхэн хөгжүүлэх, жуулчдын хүсэл сонирхол, эрийн гурван наадмын өнөөгийн байдлын талаар өөр өөрийн үзэл бодлоо илэрхийлж байгууллагынхаа танилцуулга хийсэн. Хэлэлцүүлгийн үеэр Монгол TV, ТМ Телевиз, UBS TV, TV5 TV, MASS TV, Өлзий TV, Үндэсний TV, Ikon.mn, News.mn, зууны мэдээ сонин, үндэсний шуудан сонин, МУ радио зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагууд мэдээ мэдээлэл хийсэн.



Энд байгууллагын дэргэдэх орон тооны бус бодлогын зөвлөлийн гишүүд болон үндэсний спортын төлөөллүүдийн удирдлагууд нэг дор цуглан үндэсний

спорт, өв соёл, ёс заншлаа хэрхэн хамгаалах хөгжүүлэх талаар саналаа солилцсоноороо ихээхэн ач холбогдолтой боллоо.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Байгууллагын хэмжээнд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр А тушаал 43 боловсруулагдан мөрдөгдөж байна. Үүнд: “Хөдөлмөрийн дотоод журам”, “Байгууллагын зохион байгуулалтын бүтэц”, “Ажилтан, албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Баримт бичиг нягтлан шалгах комиссын дүрэм”, “Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх журам”, Архивын дүрэм”, “Ур чадварын нэмэгдэл олгох журам”, Ажилтан албан хаагчдын 2019 оны ээлжийн амралтын хуваарь зэргийг гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн хүний нөөцтэй холбоотой 131 Б тушаал төлөвлөгдөн албажсан байна.

3.1 БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

3.1.1 Үндэсний Их баяр наадмыг тохижилт үйлчилгээний ажлыг амжилттай зохион байгууллаа.

“Монгол Наадам Цогцолбор” ОНӨТҮГ нь Үндэсний их баяр наадам, Тулгар төрийн 2228 жил, Их Монгол улс байгуулагдсаны 813 жил, Ардын хувьсгалын 98 жилийн ойн Үндэсний их баяр наадмыг “Хүй долоон худаг”-т тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөг салбар хорооноос өгсөн чиглэлийн дагуу 45 зүйлтэйгээр баталсан. “Монгол Наадам Цогцолбор” ОНӨТҮГ-ын нийт 39 ажилтан Хүй долоон худаг дахь тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний зохион байгуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу тогтоосон хугацаанд амжилттай хийж гүйцэтгэлээ.

Байгууллагын баг бүрэлдэхүүн нь наадмын зохион байгуулалтын бэлтгэл ажлыг 2 сарын өмнөөс эхлүүлж Хүй долоон худагт Үндэсний их баяр наадмын бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө 1, байгууллагын даргын тушаал 1, салбар хорооноос ирсэн төлөвлөгөөний дагуу ажил хариуцан гүйцэтгэх байгууллагын дотоод төлөвлөгөө 1-ыг тус бүр гарган мөрдөн ажиллаа. Нийт бэлтгэл ажлын хугацаанд хамт олны болон удирдлагын түвшинд 9 удаа хуралдаж төлөвлөгөөний гүйцэтгэл, чанарын хэрэгжилт, гэрээт байгууллагуудын ажлын үр дүнг хянан ажиллаж, тулгамдсан асуудлуудыг цаг тухай бүрд нь шийдвэрлэн ажилласан.

Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооноос 1 удаа, Тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний салбар хорооноос 3 удаа, Хурдан морины салбар хорооноос 2 удаа “Хүй долоон худаг”-т үзлэг шалгалт, комиссын хурал хийж, холбогдох үүрэг даалгавруудыг өгч, тохижилтын ажлын хэрэгжилтийг хянан зөвлөж ажилласан.



ҮИБН-ын Тохижилт, засвар, худалдаа үйлчилгээний салбар хороо Хүй долоон худгийн бэлтгэл ажилтай танилцаж буй нь

Баяр наадмын Тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний салбар хорооноос “Монгол Наадам Цогцолбор” ОНӨТҮГ-т 2019 онд 50,040,800 төгрөг хувиарласан. Дээрх төсвийг салбар хорооны даргаар батлуулан, төлөвлөлтийн дагуу Хүй долоон худгийн тохижилт, засвар үйлчилгээний ажилд зарцуулан ажиллаа.

Тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний салбар хорооноос Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-т хуваарилсан төсөвт ажлууд дараах чиглэлтэй байв. Үүнд:

1. Хүй долоон худаг дахь морь барианы газрын контейнерэн нийтийн бие засах газруудыг цэвэр усаар хангах, бохир соруулж тээвэрлэх ажлын зардал /36 ширхэг/
2. Цахилгаан машин ажиллуулах зардал /26 ширхэг/
3. Хүй долоон худгийн морь барианы газрын тохижилтын зардал /Контейнерэн 00 засварлах, хайс, сандал, сүүдрэвч, сэтгүүлчийн индэр будах, шинэчлэх/
4. Морь барианы газрын засвар, ногоон байгууламж хийх
5. Хүнсний хэрэгцээнд тэнцэхгүй бүтээгдэхүүн, үхсэн морьдын сэг зэм устгах нүх ухах зардал

Тохижилтын чиглэлээр хийсэн ажлууд:

Хүй долоон худгийн нийтийн эзэмшлийн хуваарьт зам талбайд усалгаа, цэвэрлэгээ, зүлэгжүүлэлт, хог тээврийн үйлчилгээ, бохир соруулалт, хогийн сав байрлуулах, сандал угсрах, контейнерэн нойл байрлуулах, цэвэрлэгээ, үйлчилгээг хариуцан ажиллуулах ажилд “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын 38 ажилтан, гэрээт байгууллагуудаас 53 ажилтан, байгууллагын 11 автомашин, техник, гэрээт байгууллагаас 14 автомашин, техник, 26 экоавтобус гарч ажилласан.

- Хүй долоон худгийн морь барианы газарт 4500 үзэгчдийн зөөврийн суудал, 178 хүний суурин суудал байрлуулан наадамчин олны хурдан морины уралдаан үзэх тав тухыг хангасан.
- Наадмын талбайд хуучин 23 байршилд, шинээр 1 байршилд контейнерэн бие засах цэгүүд байрлуулж өнгө үзэмжийг сэргээн засварлан будсан.
- Талбайд шүдлэх морины хашаа, комиссын хашаа, зурхайн хашааг байршуулан мөн өнгө үзэмжийг сэргээн будсан.

- Баяр наадмын өдрүүдээр автобусны зогсоолоос А,Б зогсоол хүртэлх 2,7 км замд нийт 26 ширхэг эко автобусаар 25 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллан наадамчин олонд үйлчилсэн.
- Морь барианы газар түүний эргэн тойрон, морьны комиссын хашаа, түүний эргэн тойронд 2 усалгааны автомашинаар наадмын өдрүүдэд 24 удаагийн рэйсээр 240 тн усалгааг хийсэн.
- Ерөнхийлөгчийн нойл болон морьны комиссын нойлын цэвэрлэгээ үйлчилгээг 4 өдрийн турш хариуцан ажилласан
- Хүй долоон худгийн радио үзелийг Монголын радио, телевизийн үндэсний сүлжээний морь дамжуулах төв станцтай холбон 4 хоногийн турш хурдан морины уралдаан болон наадамчин олонд зориулсан зарлал, мэдээ мэдээлэл болон цаг агаарын мэдээг цаг тухай бүр дамжуулж ажилласан
- Улсын Баяр наадмын талбайн хог цэвэрлэгээг Сонгинохайрхан дүүргийн Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ, Нийслэлийн Хот тохижилтын газар хариуцан ажилласан ба эдгээр байгууллагуудтай наадмын өдрүүдэд нягт уялдаа холбоотой ажиллаж холбогдох заавар, зөвлөгөөг өгч талбайн цэвэрлэгээнд хяналт тавьж ажиллаа.
- 7 дугаар сарын 12-13 нд шилжих шөнө “Уяачдын наадам”-д зориулан үзэгчдийн 500 ширхэг сандал, 6х9-ын хэмжээтэй 1 ширхэг монгол майхан, 4 ширхэг ширээ, 36 ширхэг сандлыг Соёл, урлагийн талбайн голд, үзэгчдийн 250 ширхэг сандлыг Жороо морины талбайд тус тус байрлуулж бэлтгэл ажлыг найдвартай хангаж ажилласан
- 7 дугаар сарын 13-ны өдөр Соёл, урлагийн талбай дээр зохион байгуулагдсан “Уяачдын наадам”-ын талбайн усалгаа, цэвэрлэгээ, тохижилт, зохион байгуулалтын ажлыг бүрэн хариуцаж хяналт тавьж ажилласан.
- ЗАА-ны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн захиалгаар “Хөхүүрийн айраг” арга хэмжээнд 1 ширхэг 5 ханатай гэр, 3*4 хэмжээтэй лед дэлгэц, 6*8-ийн хэмжээтэй монгол майхан зэргийг Соёлын наадмын талбайд байршуулан 07 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд лед дэлгэцийн хэвийн ажиллагааг хангаж хариуцан ажиллаа.



- Үзэгчдийн суудал засаж буй нь



- Талбайд тохижилтын ажил хийж буй байдал

2019 онд шинээр хийгдсэн тохижилт, зохион байгуулалтын ажлууд:

➤ 2018 оны зун баяр наадмын талбайд байрлуулсан нийтийн бие засах газруудын байрлал, үйлчлүүлэгчдийн төвлөрөл зэргийг харгалзан контейнерэн бие засах газруудаас 2 ширхэг бие засах газрыг хүнс үйлчилгээний талбайд ойртуулан байрлуулж ачааллыг хувиарлан наадамчин олонд үйлчилсэн.



- Байрлал өөрчлөн тавьсан контейнерэн нойлтой ҮИБН-ын Тохижилт, хүнс, худалдаа үйлчилгээний салбар хорооны гишүүд танилцаж буй нь

➤ Баяр наадмын төв талбайруу автомашины зогсоолоос иргэд алхаж очиход ашигладаг модон гүүр 20 ширхэг байдаг боловч наадамчин олны эрэлт хэрэгцээг бүрэн хангаж чаддаггүй байсан ба 2019 оны ҮИБН-аар ЗАА-аас шинээр 10 ширхэг модон гүүр нэмж байрлуулан наадамчин олон үйлчиллээ.



- Шинэ гүүрнүүдийг талбайд байрлуулж буй нь

- Хүй долоон худагт байрлалтай контейнерэн нойлуудын хүрэлцээ бага байдаг бөгөөд жил ирэх тусам наадамчин олон болон жуулчдын тоо өсөн нэмэгдэж буйтай холбогдуулан нийтийн бие засах газруудын тоог нэмэгдүүлэх саналыг ҮИБН зохион байгуулах комисст хүргүүлж ажилласан.. Үүний үр дүнд НЗАА-аас Хүй долоон худагт ҮИБН-аар 20 ширхэг био нойлыг автомашины зогсоол болон нийтийн бие засах газар хүрэлцдэггүй байршлуудад шинээр байршуулан наадамчин олон үйлчиллээ.

- **Салбар хорооны төсөвт ажлууд:**

3.1. Хүй долоон худаг дахь морь барианы газрын контейнерэн нийтийн бие засах газруудыг цэвэр усаар хангах, бохир соруулж тээвэрлэх ажил /36 ширхэг/

Хүй долоон худагт 2019 оны 7 дугаар сарын 09-ны өдрөөс 13-ны өдрийг дуустал наадамчдад үйлчлэх нийтийн бие засах газруудыг цэвэр усаар хангах, бохир соруулж тээвэрлэх төсвийг Тохижилт засвар, худалдаа, үйлчилгээний салбар хорооноос 28,317,800 төгрөгөөр баталсан. Батлагдсан төсвийн хүрээнд мэргэжлийн компаниудаас ирүүлсэн саналыг хүлээн авч шалгаруулан “Суман хас” ХХК, “Говийн марз” ХХК, “Дэлгэр баян хайрхан” ХХК-тай тус тус 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдөр МНЦ 19/034, 19/033, 19/036 тоот гэрээнүүдийг байгуулсан. Тус гурван байгууллага нь Хүй долоон худаг дахь морь барианы газрын нийтийн бие засах газруудыг цэвэр усаар хангах, бохир усыг соруулж төв цэвэрлэх байгууламж руу татан зайлуулах үүрэгтэй хүлээж ажилласан. Эдгээр 3 компани нь баяр наадмын өдрүүдэд 28 хүний бүрэлдэхүүнтэй цэвэр ус тээвэрлэх 8, бохир тээвэрлэн асгах 10 автомашинтайгаар баяр наадмын талбайн нийтийн бие засах газрын үйлчилгээг бүрэн хариуцан ажилласан.

➤ Нойлуудын байрлалын хувьд Ерөнхийлөгчийн хотхонд 1 ширхэг, Баяр наадмын комисст 1 ширхэг, Цагдаа толгойд 2 ширхэг, “Монгол Наадам Цогцолбор”-ын оффист 1 ширхэг, үйлчилгээний А, Б талбайд 31 байрлалд нийт 36 ширхэг контейнерэн нойлуудыг байршуулан наадамчин олонд үйлчиллээ.

➤ Ус сувгийн удирдах газрын 5 худаг, Монгол наадам цогцолборын 1 нийт 6 худгаас 1100 тн цэвэр ус нийлүүлж, 1354 тн бохир ус соруулан цэвэрлэх байгууламжийн бохирын цооногт нийлүүлсэн байна.

➤ Хүй долоон худгийн хүнсний талбайд 60 тонн, соёл, урлагийн талбайд 50 тоннын бохирын нөөц сав байдаг. Баяр наадмын ид ачаалалтай өдрүүдэд тус бохирын нөөцийн саванд өдрийн цагаар нойлуудын бохирыг хуримтлуулж наадамчин олгы ачаалал багасах үеэр нөөцийн бохирын савнаасаа Улаанбаатар хот төв цэвэрлэх байгууламж руу тээвэрлэн зөөж ажилласан. Үүний үр дүнд Хүй долоон худгийн 36 цэгт байрлалтай нойлуудын бохирыг цаг тухай бүрд нь соруулан үйл ажиллагааг саадгүй хэвийн явууллаа.

➤ 07 дугаар сарын 10-13-ны хооронд нийтийн бие засах газруудад гарсан бохирын бөглөөсийг гарган, шатсан эргэлтийн насосуудыг солих, нойлуудын хаалганы нугас, хөвүүр, уян холбоо, холигч, гэрлийн ламп, бусад жижиг эвдрэл гэмтлийг цаг тухайд засаж сэргээж ажилласан.



- Нойлуудад цэвэр ус нийлүүлж бохир соруулж буй байдал

Хүнсний хэрэгцээнд тэнцэхгүй бүтээгдэхүүн, үхсэн морьдын сэг зэм устгах нүх ухах ажил

Баяр наадмын өдрүүдэд хүнсний хэрэгцээнд тэнцэхгүй бүтээгдэхүүн, эндсэн морьдын сэг зэм устгах зориулалт бүхий 6 х 5-ийн хэмжээтэй 4 метрийн гүнтэй нүх ухах ажлыг 500,000 төгрөгийн төсвөөр гүйцэтгэхийг баталсан. Гэвч уг төсөв нь заасан хэмжээний нүх ухах зардалд хүрэхгүй байсан тул бусад засвар үйлчилгээний төсвөөс хэмнэлт гарган “Дэлгэр баян хайрхан” ХХК-тай МНЦ 19/036 тоот гэрээг 872,800 төгрөгөөр 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдөр байгуулан 6х5-ийн хэмжээтэй 4 метрийн гүнтэй эндсэн мал булах нүх 1 ширхэгийг ухуулж бэлтгэсэн. Тус нүхэнд хурдан морины уралдаанаас эндсэн морьдийг булсан.



6х5-ын хэмжээтэй эндсэн морины нүх ухсан байдал, ашиглагдсан байдал

Экобус - Цахилгаан машин ажиллуулах зардал /26 ширхэг/

Цахилгаан машин ажиллуулах зардлын төсвийг Тохижилт засвар, худалдаа, үйлчилгээний салбар хорооноос 10,658,100 төгрөгөөр баталсан. Тус захиалгат ажлыг “Өнө хангай” ХХК-тай 2019 оны 06 дугаар сарын 21-ны өдөр МНЦ 19/027 тоот цахилгаан автобусаар наадамчдад үнэ төлбөргүй үйлчлэх үүрэгтэй гэрээг байгуулсан. Мөн “Цэнхэр харгиа” ХХК-тай 2019 оны 06 дугаар сарын 21-ны өдөр МНЦ 19/028 тоот цахилгаан автобусны аккумулятор сэргээж, тос, тослох материал сольж, завсар үйлчилгээ хийх гэрээг тус тус байгуулан хамтран ажиллаа. Захиалгат ажил гүйцэтгэх хугацаандаа “Өнө хангай” ХХК жолооч, ажилчдын бэлэн байдлыг 100% ханган, цэнэглэлт, техникийн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж, үйлчилгээний стандартыг бүрэн мөрдөж, аюулгүй ажиллагаандаа өндөр анхаарал тавин гэмтэл, зөрчил гаргалгүйгээр хамтран ажиллаа.

“Цэнхэр харгиа” ХХК-ийн хувьд нийт 16 ширхэг экоавтобусны аккумуляторыг шинэчлэн тавьж дагалдах тос, тосолгоо болон бусад засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсэн ба цаашид экоавтобуснуудын аккумуляторууд бүрэн солихгүй бол дахин цэнэглэх боломжгүй болсныг тэмдэглэн хэлсэн.



Наадамчдад цахилгаан автобусаар үйлчилж буй нь

Соёл, урлагийн талбайд худалдаа, үйлчилгээний зөвшөөрөл олгох, талбайг зохион байгуулах ажлын хүрээнд:

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ УИБН-ын Тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний салбар хорооноос гаргасан удирдамжийн дагуу Хүй долоон худгийн Соёл, урлагийн талбайд гар урлал, бэлэг дурсгал, соёлын барааны худалдаа, кофе шоп, хөдөлгөөнт тоглоомын чиглэлээр 100 ширхэг зөвшөөрөл олгон талбайн зохион байгуулалтад хяналт тавин хариуцан ажилласан.

➤ Соёл, урлагийн талбайд нийт 100 ширхэг зөвшөөрөл олгогдсон ба албан ёсны зөвшөөрөл авсан иргэд заасан талбайд байрлан эмх, цэгцтэйгээр худалдаа үйлчилгээгээ явуулсан. Олгогдсон зөвшөөрлийг төрлөөр ангилж үзвэл кофе шоп 5 ширхэг, гар урлал, бэлэг дурсгал, соёлын барааны худалдаа 38 ширхэг, хөдөлгөөнт тоглоомын үйлчилгээ 43 ширхэг, ус ундаа, зайрмаг худалдаа 10 ширхэг, олон нийтэд үйлчлэх зөөврийн АТМ машин 1 ширхэг, нэгж худалдаалах үүрэн

телефоны машин 1 ширхэг /Мобиком/, гэрэл зураг авах үйлчилгээ 2 ширхэг тус тус ажилласан.



Соёл, урлагийн талбайн зохион байгуулалт, худалдааны гудамжны харагдах байдал



Соёл, урлагийн талбайн зохион байгуулалт, иргэд үйлчлүүлж буй нь

➤ Соёл, урлагийн талбайд үйл ажиллагаа явуулж байгаа хөдөлгөөнт тоглоомуудад СХД-ын Мэргэжлийн хяналтын хөдөлгөөнт тоглоом хариуцсан байцаагчтай хамтран хяналт тавьж ажилласан бөгөөд шаардлага хангахгүй тоглоомыг дор бүр нь буулган, цахилгааныг нь салгуулан шуурхай арга хэмжээ авч ажиллаа. Хяналтын явцад хүүхдийн бие, эрхтэнд гэмтэл учруулахуйц төрлийн тоглоомыг ашиглахыг хориглож ажилласан.

➤ Соёл, урлагийн талбайн онцлох худалдаа, үйлчилгээний хувьд Хаан банкны явуулын АТМ, үүрэн телефоны Мобиком компанийн явуулын үйлчилгээ, “Green bike” компанийн унадаг дугуйн үйлчилгээ, “Tom’n Toms” кофе шоп, “Цэрэн тур” Голланд кофе шопийн жуулчдад зориулсан халуун кофений үйлчилгээ, “Toyota” компанийн Монгол дахь албан ёсны төлөөлөгч компанийн тохижуулсан лед дэлгэц, НАЖГ-ын жуулчдад мэдээлэл хүргэх цэг, үндэсний гар урлал, арьсан эдлэл, модон эдлэл, монгол үндэсний дээл хувцас, эмээл хазаар, морины эд хэрэгсэл, мэргэжлийн гэрэл зурагчин, хүүхдийн галт тэрэг зэргийг нэрлэж болох юм. Дээрх үйлчилгээнүүдийг Соёл, урлагийн талбайд гудамж үүсгэн байршуулж, явган хүний гарц, шаардлагатай тохиолдолд автомашин орох зам талбайг чөлөөлөн зохион

байгуулсан нь оновчтой байж үйлчлүүлэгчид болон худалдаа, үйлчилгээ эрхлэгчид сэтгэл хангалуун байлаа.



“Toyota” компанийн лед дэлгэцээр байгууллагын сурталчилгаа болон хурдан морины уралдаан, үндэсний бөхийн барилдааныг наадамчдад шууд дамжуулан үзүүлж буй байдал

- Наадамчид Хаан банкны АТМ машинаар үйлчлүүлж буй байдал

➤ Соёл, урлагийн талбайн зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-аас зохион байгуулагчдын гэр гарган талбайд байрлуулж үйл ажиллагаа явуулж буй иргэд, ААН-үүд болон үйлчлүүлж буй наадамчин олонд мэдээлэл хүргэн, байршлын хөтөч брошур тараан, УИБН-ын Хүй долоон худгид дахь зохион байгуулалт, үйлчилгээний талаар судалгаа авч ажиллаа.

Олон нийтийн оролцоотой шинээр санаачлан хэрэгжүүлсэн ажлууд:

➤ “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ нь “Toyota” ХХК-ийн монгол дахь албан ёсны төлөөлөгч компани болон “Миг даатгал” ХХК-тай хамтран “Хүй долоон худгийн байршлын хөтөч” бүдүүвч зургийг 10.000 хувь хэвлэн 3 дахь жилдээ Хүй долоон худгийг зорин ирдэг наадамчин олонд зориулан үнэ төлбөргүйгээр тарааж зөвөлгөө өгч ажиллаа. Уг байршлын хөтөч нь Хүй долоон худгийн ерөнхий схемд байрлалын зураг, соёл урлагийн үзвэр үйлчилгээний цэгүүд, хоол, хүнсний худалдааны цэгүүд, түргэн, гал команд, онцгой байдлын газар, цагдаа хүрээ, Яам, тамгын газрын байрлал, хурдан морь барианы газар, автомашины зогсоол, хогийн цэг, радио үзель буюу зарлан мэдээллэх цэг зэргүүдийн холбогдох утасны дугааруудыг наадамчин олонд гарын авлага байдлаар хүргэх зорилготой юм.



Хүй долоон худгийн байршлын хөтчийн загвар

Үндэсний их баяр наадам, Тулгар төрийн 2228 жил, Их Монгол улс байгуулагдсаны 813, Ардын хувьсгалын 98 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ нь 2019 оны төлөвлөгөөт ажлуудаа бүрэн гүйцэтгэж ажиллаа.

Хүй долоон худгийн тохижилт, үйлчилгээний ажлууд төлөвлөгөөний дагуу цаг хугацаандаа хийгдэж нийт талбайн зохион байгуулалт эмх цэгцтэй байж, нийтийн бие засах газрын үйлчилгээ, цэвэрлэгээнд анхаарч, орчны тохижилтыг сайжруулан хуурайшилтын үед талбайн усалгааг нэмэгдүүлэн наадамчин олны тав тухыг хангаж ажиллаа.

2019 оны ҮИБН-аар шинээр хийгдсэн тохижилтын ажлуудын хувьд:

- Хүн их төвлөрдөг 2 байрлалд контнейрэн нойлыг шинэчлэн байрлуулсан
- ЗАА-аас 20 ширхэг био нойлыг автомашины зогсоолууд дээр нэмэж байршуулан цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан ажиллаа
- Явган хүний модон гүүр 10 ширхэгийг авто замын хажуугаар байршуулсан.
- 16 ширхэг экоавтобусны аккумуляторыг шинэчлэн сэргээсэн зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд наадмын оргил ачааллын үеэр нойлуудын зөв байршилд байршуулсанаар нийтийн бие засах газрын ачааллыг багасгаж чадсан.
- Мөн “Хүй долоон худгийн байршлын хөтөч” брошурыг 3 дахь жилдээ хэвлэн олон нийтэд үнэгүй тарааж буй нь наадамчин олонд сэтгэл хангалуун байлаа.

Тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний салбар хорооноос баталж өгсөн зардал болох 50,040,800 төгрөгийн 70% буюу 34,747,000 төгрөг зарцуулагдаж, үлдэгдэл 30% буюу 15,293,800 төгрөгийн санхүүжилт гүйцэтгэлээрээ хийгдсэн. Нийт төсвийг бүрэн зарцуулсан бөгөөд төсөвт тусгагдаагүй бусад тохижилт үйлчилгээтэй холбоотой холбогдох зардлыг өөрийн урсгал зардлаас санхүүжүүлэн хийлээ.. Гүйцэтгэлийг гэрээний дагуу хүлээн авч, хянан шалгаж, гэрээ дүгнэсэн акт үйлдэн гэрээг ажиллаж ажилласан.

3.1.2. “Эрүүл иргэн-Эко хөгжил 2019” спорт өдөрлөгийг Хүй долоон худагт зохион байгууллаа

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-аас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Эрүүл иргэн-Эко хөгжил” спорт өдөрлөг 5 дахь жилдээ “Хүй долоон худаг”-т 05 дугаар сарын 24-ний өдөр амжилттай зохион байгуулагдлаа.

Тус спорт өдөрлөг нь Нийслэлийн иргэд, хүүхэд залуусыг Хүй долоон худгийн эрүүл цэвэр агаарт спортоор хичээллэх орчныг нэмэгдүүлэх, хүүхэд залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох, бүх нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилгоор жил бүр зохион байгуулдаг уламжлалтай. Уг спорт өдөрлөг нь тав дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа бөгөөд иргэд олон нийтэд хэдийнээ танил болоод байна.

Жилээс жилд өргөжин хүүхэд залуус мэддэг болж байгаа тус спорт өдөрлөгийг хүн болгонд хүргэх үүднээс дүүргүүдийн ЕБС-ын ахлах ангийн сурагчдаас гараагаа эхэлж байна. Энэ жилийн хувьд СХД-ийн ЗДТГ болон тус дүүргийн Биеийн тамир, Спортын хороо мөн тус дүүргийн Боловсролын хэлтэстэй хамтран дүүргийн

Ерөнхий боловсролын нийт 15 сургуулийг хамруулан зохион байгуулахаар төлөвлөсөн. Хамрагдсан байдлын хувьд 3 сургууль тусгайлсан шалгалттай оролцох боломжгүй хэмээн мэдэгдсэнээр нийт 12 сургуулийн ахлах ангийн 400 гаруй сурагчдыг хамруулан зохион байгууллаа.

Тус өдөрлөгийн үеэр:

- 3Х3 сагсан бөмбөгийн тэмцээн
- Хөгжөөнт буухиа багийн тэмцээн
- Сонирхогчдын уулын дугуйн марафон
- Сонирхогчдын холын зайн гүйлт зэрэг 4-н төрлийн тэмцээн тус бүр эрэгтэй, эмэгтэй насны ангилалаар зохион байгуулан хүүхэд багачуудын хүч чадал, авхаалж самбаа, авьяас чадварыг сорьсон юм. Мөн өдөрлөгийн үеэр урлагийн тоглолт флаш моби зэрэг хөгжөөнт хөтөлбөрүүд зохион байгуулагдсан бөгөөд тус арга хэмжээнд хүүхдүүд идэвхтэй оролцож байсан.

Оролцсон сургуулийн хамрагдсан байдал:

“Эрүүл иргэн – Эко хөгжил-2019” спорт өдөрлөгийг 2019 оны 05 дугаар сар 24-ний баасан гаригт Хүй долоон худагт зохион байгуулсан бөгөөд өдөрлөгт оролцох дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг Сонгинохайрхан дүүргийн засаг даргын тамгын газрын үүднээс өглөөний 10:00 цагаас тусгайлан бэлдсэн нийтийн тээврийн автобусаар хүй долоон худагт хүргэн орой нь 18:00 цагт Сонгинохайрхан дүүргийн засаг даргын тамгын газрын үүдэнд хүргэж өгсөн. Мөн тэмцээнд оролцох хүүхдүүдийн унадаг дугуйг том оврын ачааны автомашинаар тээвэрлэж ажиллаа.



“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дарга Д.Хатанбаатар тус арга хэмжээг нээж үг хэлэв.



Сонгинохайрхан дүүргийн засаг даргын тамгын газрын үүднээс хөдөлж буй тусгай зориулалтийн нийтийн тээврийн автобус

Тайзны арга хэмжээ:

“Эрүүл иргэн-Эко хөгжил 2019” спорт өдөрлөгийг Диамонд продакшны хөтлөгч Дөөмөө хөтлөн хүүхэд залуусыг арга хэмжээнд идэвхижүүлэн хөгжөөж байсан. Мөн хүүхэд залуусдаа ая дууны мэндчилгээ дэвшүүлэхээр дуучин Г.Төгөлдөр, СУИС-ын дэргэдэх Квартит хамтлаг, UB dance бүжгийн клубийн багш нар флаш моба бүжиг заан, “Монголын экстрем дугуй сонирхогчдын холбоо”-ны тамирчид үзүүлбэр үзүүлсэн юм.



Талбайд хүүхэд залуус экстрем дугуйн үзүүлбэр үзүүлж буй нь

Нэг. 3Х3 сагсан бөмбөгийн тэмцээн

3х3 сагсан бөмбөгийн тэмцээнд сургууль бүрээс эрэгтэй нэг, эмэгтэй нэг баг оролцуулан авхаалж самбаа, авьяас чадварыг сорин өрсөлдүүлж тэмцээнд оролцсон нийт багуудаас нэг, хоёр, гуравдугаар байр эзлүүлэн алт, мөнгө, хүрэл медаль өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. Мөн тус тэмцээнд оролцсон нийт сурагчдаас шилдэг эрэгтэй тамирчин, шилдэг эмэгтэй тамирчин шалгаруулан шилдэг тамирчины цом, өргөмжлөл, медаль мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан байгаа. Тэмцээний эрэгтэйчүүдийн төрөлд 13 баг, эмэгтэй төрөлд 12 баг оролцсон.

Эрэгтэй төрөлд байр эзлэсэн сургуулиад:

1. Б.Ачиймаа багштай 105-р сургууль тэргүүн байр

2. Ц.Энхбаатар багштай 62-р сургууль дэд тэргүүн байр
3. Ж.Соёл-Эрдэнэ багштай 42-р сургууль гутгаар байр эзэлсэн

Эмэгтэй төрөлд байр эзлэсэн сургуулиад:

1. 62-р сургуул Энхбаатар багштай баг тэргүүн байр
2. 105-р сургуул Д.Саранзаяа багштай баг дэд тэргүүн байр
3. 122-р сургуул Баярсайхан багштай баг гутгаар байр



3х3 сагсан бөмбөгийн эрэгтэй эхний гурван байрт шалгарсан сургуулиуд



3х3 сагсан бөмбөгийн эмэгтэй эхний гурван байрт шалгарсан сургуулиуд

Хоёр. Сонирхогчдын уулын дугуйн тэмцээн

Сонирхогчдын уулын дугуйн тэмцээнийг эрэгтэй, эмэгтэй хоёр төрлөөр зохион байгуулан эрэгтэй тамирчид 5км-т эмэгтэй тамирчид 3км-т өрсөлдсөн. Тэмцээний талбайн хувьд Хүй долоон худгийн морь барианы газарт тусгайлан бэлтгэсэн гарааны хэсгээс гарган 2,5км газраас эрэгтэй тамирчдыг буцаж эргэхээр тооцоолсон бол эмэгтэй тамирчдыг 1,5км газраас буцаж эргэхээр тооцоолон тойруу замаар өрсөлдүүлсэн. Тус тэмцээнд авьяас чадвар, хурд хүч, авхаалж самбаагаа сорин 13 сургуулийн 59 сурагч оролцсон.

Эрэгтэй уулын дугуйн тэмцээний төрөлд 13 сургуулийн 43 хүүхэд өрсөлдсөнөөс

1. 107-р сургуулийн Б.Чимэдрагчаа тэргүүн байр
2. 65-р сургуулийн Б.Батбаатар дэд тэргүүн байр
3. 65-р сургуулийн М.Амарболд гутгаар байранд тус тус шалгарсан.

Эрэгтэй уулын дугуйн тэмцээний төрөлд 12 сургуулийн 13 хүүхэд өрсөлдсөнөөс

1. 65-р сургууль Х.Катя тэргүүн байр

2. 65-р сургууль Б.Сувдмаа дэд тэргүүн байр
3. 9-р сургууль Б.Норжинсүрэн гутгаар байранд тус тус шалгарсан.



Сонирхогчдын уулын дугуйн марафон /эрэгтэй/



Сонирхогчдын уулын дугуйн марафон /эмэгтэй/

Гурав. Сонирхогчдын холын зайн гүйлтийн тэмцээн

Сонирхогчдын холын зайн гүйлтийн тэмцээнийг мөн Хүй долоон худгийн морь барианы газар зохион байгуулсан. Тамирчдыг эрэгтэй 5км, эмэгтэй 3км-ийн зайд тойруу замаар буцан эргэх зохион байгуулалттайгаар өрсөлдүүлэн хурд хүч, авхаалж самбааг сорьсон. Тус өдөр цаг агаарын сэрүүн салхитай байсны улмаас тамирчдад бахардах, агаарын солбилцолд орон амьсгаа давчдах зэрэг хүндрэл бэрхшээл тулгараагүй. Тэмцээнд оролцож байр эзэлсэн тамирчин хүүхдүүдийг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

Тэмцээнд 13 сургуулийн 56 хүүхэд оролцон хурд хүч, авхаалж самбаагаа сорьсон юм.

1. 123-р сургуулийн Д.Дамдиндорж тэргүүн байр
2. 74-р сургуулийн Т.Түмэнхулан дэд тэргүүн байр
3. 121-р сургуулийн Ө.Ганбодь гутгаар байр

Нийт 13 сургуулийн 46 хүүхэд оролцсон

Сонирхогчдын холын зайн гүйлт 3000 метр /эмэгтэй/

1. 74-р сургуулийн М.Намуунаа тэргүүн байр

2. 65-р сургуулийн Т.Маралмаа дэд тэргүүн байр
3. 9-р сургуулийн Н.Хулан гутгаар байр Нийт 13 сургуулийн 19 хүүхэд оролцсон.



Сонирхогчдын холын зайн гүйлт 5000 метр /эрэгтэй/



Сонирхогчдын холын зайн гүйлт 3000 метр /эмэгтэй/

Дөрөв. Хөгжөөнт бүүхиа тэмцээн

“Эрүүл иргэн- Эко хөгжил” 2019 спорт өдөрлөгт оролцсон нийт сурагчдын идэвхи оролцоог бүрэн хангаж бүрэн хамруулах үүднээс багийн хөгжөөнт бүүхиа тэмцээнийг нийт сургуулиудын дунд зохион байгуулсан. Тус тэмцээнд нэг сургуулиас тус бүр 5 эрэгтэй, 5 эмэгтэй сурагч, нэг багш орж өрсөлдсөн. Тэмцээний хувьд нийт тамирчид 8-н төрлийн этапаар хоёр хоёроороо хос болон даалгавар биелүүлж өрсөлдүүлэн хамгийн богино хугацаанд орж ирсэн хугацаагаар нь Нэг, хоёр, гуравдугаар байр эзлүүлсэн. Байр эзэлсэн сургуулиудыг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл мөнгөн шагнал, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулсан.

1. 105-р сургууль 1 минут 37 секунд 04 дойлоор тэргүүн байр
2. 107-р сургууль 1 минут 45 секунд 21 дойлоор дэд тэргүүн байр
3. 76-р сургууль 1 минут 46 секунд 64 дойлоор гутгаар байр

Нийт 13 сургуулийн 12 баг оролцсон

Нийт энэхүү 4-н төрөлт тэмцээний нийлбэр оноогоор үнэмлэхүй амжилт гаргаж түрүүлсэн нэг сургуулийг “Эрүүл иргэн – Эко хөгжил 2019” спорт өдөрлөгийн нэрэмжит “ШИЛДЭГ СУРГУУЛЬ”-иар өргөмжилж цом, өргөмжлөл, дурсгалын зүйл мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.

“Эрүүл иргэн – Эко хөгжил -2019” спорт өдөрлөгийн шилдэг сургуулиар Б.Ачиймаа багштай 105-р сургууль шалгарсан.



“Эрүүл иргэн- Эко хөгжил 2019” спорт өдөрлөгийн шилдэг сургуулиар шалгарсан СХД-ийн 105-р сургуулийн хамт олон шагналаа гардан авч буй нь

Тус өдөрлөгийн үеэр Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн 14 дүгээр төвийн ахлах сувилагч Чонцолдуламийг ажлуулан тэмцээн уралдаанд оролцсон хүүхдүүдийн эрүүл мэнд аюулгүй байдлыг хангаж ажилласан. Талбайн тохижилтын хувьд “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-аас 3х3 сагсан бөмбөгийн тэмцээний эрэгтэй, эмэгтэй тоглолтын талбай, уулын дугуйн аварга шалгаруулах тэмцээний гараа, бариа, мөн холын зайн гүйлтийн гараа, барианы хэсгийг тохижуулан талбайд хүүхдүүдийн тэмцээн уралдаан зохион байгуулах нөхцөлийг хангаж ажилласан.

Хөгжөөнт буухиа тэмцээний хувьд Сонгинохайрхан дүүргийн биеийн тамир спорт хороотой хамтран 8 төрлийн даалгавар биелүүлэх тэмцээний гараа, барианы хэсгийг тохижуулан хүүхдүүдийг өрсөлдүүлсэн. 2019 оны 5 дугаар сар 24-ний өдөр хэдийгээр цаг агаар сэрүүвтэр бороо хуртай байсан хэдий ч тэмцээнд хүрэлцэн ирсэн хүүхдүүд идэвхи, санаачилгатай оролцон багийн амжилт үзүүлэхийн тулд хичээж байгаа нь харагдаж байсан. Мөн “Эрүүл иргэн – Эко хөгжил 2019” спорт өдөрлөгийг өргөн хүрээтэй хамруулах үүднээс идэвхжүүлэлтийг сошиал сайт болон веб сайтуудад байршуулан, “Үндэсний шуудан” сонинд А4 хэмжээтэй постер байршуулан олон нийтэд хүргэсэн. Мөн тус өдөрлөгийн үеэр зураглаач ажиллуулан үйл ажиллагаа, уралдаан тэмцээний бүхий л үйл явцыг дүрсжүүлэн байгууллагын архивт үлдээсэн. Тус өдөрлөгийн тайлан мэдээг бэлтгэн нийт 8 портал сайтад байршуулан олон нийтэд хүргэн ажиллалаа.

Жилээс жилд цар хүрээгээ тэлэх болсон “Эрүүл иргэн – Эко хөгжил” спорт өдөрлөг нь дараа жилээс дүүрэг бүрээс хүн бүрийн оролцоог нэмэгдүүлж, зохион байгуулж байхаар зорин ажиллаж байна. Энэ жилийн хувьд оролцож буй анхны дүүрэг нь Сонгинохайрхан дүүрэг юм.



Дүгнэлт:

Хүй долоо худгийн задгай талбайд Нийслэлийн хүүхэд залуучуудыг эрүүл цэнгэг агаарт чөлөөт цагийг зөв боловсон өнгөршүүлэх зориготойгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулсаар ирсэн “Эрүүл иргэн –Эко хөгжил 2019” спорт өдөрлөгийг энэ жилээс дүүргүүдээр тойрон аялуулж нийслэлийн бүх хүүхэд залуучуудыг хамруулахаар шийдсэн. Тус шинэлэг санаачлагын хүрээнд 2019 оны эхний дүүрэг Сонгинохайрхан дүүрэг байлаа.

Энэхүү гараагаа Сонгинохайрхан дүүргээс эхлүүлсэн бөгөөд тус өдөрлөгийг дүүргийн бүх ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд зохион бйагуулсан. Нийт сурагчдыг мэргэжлийн шүүгчдээр шүүлгэн спортын тэмцээн уралдаанаар өрсөлдүүлсэн нь дүүргийн сургуулиудын эв найрамдлыг нэгтгэн, хооронд нь танилцуулан бие биенээ таньж мэдэх боломжийг олгосон нэгэн сонирхолтой өдөрлөг болж чадсан бөгөөд мөн хурд хүч, авьяас чадварыг сорьсон оновчтой санаачилга байсан юм. Мөн дараа жил дараагийн дүүргийг сонгон авч спорт өдөрлөгөө зохион байгуулахаар төлөвлөж байна. Тэмцээн уралдаан зохион байгуулахад тулгарч байсан хүндрэл бэрхшээлийн хувьд Хүй долоо худгийн зам талбайд цаг агаар тогтворгүй байдгаас төлөвлөсөн ажил хойшлох магадлалтай байдаг. Зуны улиралд тус арга хэмжээг зохион байгуулахад хүүхэд, залуус амарсан байдагтай холбогдуулан идэвхи, оролцоо багасдаг. Иймээс тус өдөрлөгийг Нийслэлийн хэмжээнд өвлийн цасны баярын арга хэмжээтэй уялдуулан зохион байгуулвал тохиромжтой юм.

3.1.3 “Монгол хүү - 2019” хүүхдийн баярыг Хүй долоон худагт зохион байгууллаа

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Хүүхдэд ээлтэй Улаанбаатар” хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах

өдрийг тохиолдуулан 2019 оны 6 дугаар сарын 01-ний өдөр Хүй долоон худагт Монгол Үндэсний хэв шинж маягийг агуулсан уламжлалт “Монгол хүү – 2019” хүүхдийн баярыг “Хөх морьт” морь уналга, сургалтын төвтэй хамтран гаргасан удирдамж, ажлын төлөвлөгөө, төсвийн хүрээнд амжилттай зохион байгууллаа.

“Монгол хүү” Үндэсний хүүхдийн баярын энэ жилийн онцлогийн хувьд “Гийнгоо” анхдугаар наадам нэрийн дор “Хонгорын хурд” Морин спорт уяачдын холбоотой хамтран “МОНГОЛ ТУУРГАТНЫ ХУРДАН МОРЬ УНААЧ ХҮҮХДҮҮДИЙГ АЛДАРШУУЛАХ” зориготойгоор Олон улсын хүүхдийн эрхийг хамаалах өдрийг тохиолдуулан Хүй мандлын ногоон дэнж дээр ийнхүү зохион байгуулсан. Мөн тус арга хэмжээг СХД-ийн ЗДТГ, “Хонгорын шинэ эрин” ХХК нар хамтран зохион байгуулсан юм.



Монгол үндэсний өв соёл, язгуур урлаг, эрийн гурван наадмыг хүүхэд байгачууддаа сурталчилан таниулах, Хүй долоон худгийг үндэсний спортын төв цогцолбор болгон өргөжүүлэх зориготойгоор зохион байгуулдаг. “Монгол хүү 2019” хүүхдийн баяр олонсонирхолтой тэмцээн уралдаан, хөгжөөнт тоглоом, тайзны уран бүтээлээр дүүрэн байж Хүй долоон худгийг зорин ирсэн хүүхэд багачууд цэвэр агаарт нэгэн өдрийг эцэг, эхчүүд анд нөхдүүдтэйгээ хөгжилдөн тоглож өнгөрүүлсэн юм. Энэ өдөр хүүхэд багачуудыг хөгжөөх үүднээс бүтэн өдрийн тайзны арга хэмжээ зохион байгуулагдаж, хурдан морь унаач хүүхдүүдийг алдаршуулах “Гийнгоо” хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулагдан дуу, шүлэг, хөгжөөнт буухиан тэмцээн зохион байгуулагдаж үндэсний сур харваан тэмцээн, хүүхдийн бөхийн барилдаан зохион байгуулагдаж, морь унуулах үйлчилгээ талбайд явагдсан юм. Баярын өдөрлөгт хүүхэд, багачуудаа баярлуулахааар ирсэн аав, ээж, ах, эгч, эмээ, өвөө, нарын дунд зохион байгуулагддаг гэр бүлийн буухиа тэмцээн амжилттай зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд нийт 7 гэр бүл оролцон 3 төрлийн бартаатай буухиа тэмцээнд хурд хүч, авьяас чадвараа дайчлан оролцож Л.Баярхүүгийн гэр бүл 1-р байр, Т. Баттогтохын гэр бүл 2-р байр, Г. Балжиннямын гэр бүл 3-р байрыг эзлэн өргөмжлөл, дурсгалын зүйлээр тус тус шагнагдсан юм.



Хэн сайн морьны дуу мэдэх вэ? Тэмцээн:

Баярын арга хэмжээний үеэр тайзнаа 2 насны ангилалд дууны тэмцээн зохион байгууллаа. Бага, дунд насны ангилалд дууны тэмцээнд оролцсон хүүхэд багачууд тайзнаа өөрийн хамгийн сайн морины дуугаа дуулж өрсөлдөн авьяас чадвараа сорьсон юм. Энэхүү тэмцээний 2 насны ангилалд нийт 17 хүүхэд оролцсон нь хамгийн олон өрсөлдөгчтэй тэмцээн байлаа.

Хэн хамгийн олон морины шүлэг мэдэх вэ? Тэмцээн:

Энэ өдөр тайзнаа зохион байгуулагдсан дараагийн тэмцээн бол Морины шүлэг, уран уншлагийн тэмцээн байсан. Энэхүү тэмцээнийг 4-7, 8-12 гэсэн 2 насны ангилалд зохион байгуулан тус бүр ялагчдыг шалгаруулан өргөмжлөл, дурсгалын зүйл, гарын бэлгээр шагнасан юм. Тус тэмцээнд нийт 13 хүүхэд оролцсон.



Хэн сайн морины дуу дуулах тэмцээн



Хэн хамгийн олон морины шүлэг мэдэх вэ тэмцээн

Ерөнхий зохион байгуулалт:

Хүүхдийн баярын арга хэмжээний зохион байгуулалтад “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ –ын нийт 35 ажилтан албан хаагчид оролцсон бол СХД-ийн Цагдаагийн 1 дүгээр хэлтсээс 30 хүний бүрэлдэхүүнтэй эргүүлийн цагдаагийн баг, СХД-ийн замын цагдаагийн хэлтсээс 15 хүний бүрэлдэхүүнтэй замын цагдаагийн баг тус тус ажиллан баярын арга хэмжээний зам талбайн аюулгүй байдлыг ханган ажиллаа.

Энэхүү баярын арга хэмжээнд УБ хотоос үзэж сонирхохоор 1000 орчим хүүхэд багачууд, Хүй долоон худаг орчмын Төв аймгийн аргалант сум, СХД-ын 32-р хорооноос 200 орчим хүүхэд, урлагийн номер үзүүлэх 100 хүүхэд хүрэлцэн ирсэн бөгөөд “Гийнгоо аялах тэмцээн”, “Морины цол дуудах тэмцээн” “Морины дэл сүүл хэн сайн боох вэ?” тэмцээнд оролцохоор орон нутгаас 40 орчим хүүхэд, хүүхдийн бөхийн барилдаанд оролцохоор 65 хүүхэд, өсвөрийн сур харваан тэмцээнд оролцохоор 37 хүүхэд буюу нийт 2000 орчим хүүхэд хүрэлцэн ирж нэгэн өдрийг эрүүл цэнгэг агаарт хөгжилдөн тоглож өнгөрүүлээ.

Баярын арга хэмжээг нээж “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дарга Д.Хатанбаатар, “Хөх морьт” адуу, морь уналгын төвийг үүсгэн байгуулагч В.Дамдинсүрэн нар үг хэлэн ирсэн зочид, хүүхэд багачууддаа баярын мэнд дэвшүүлсэн. Баярын арга хэмжээ 12:00 цагт эхлэн 17:30 цагт өндөрлөсөн юм.



Энэ өдөр хүүхэд багачуудыг хөгжөөсөн нэгэн зүйл бол үлгэрийн баатар Мики Маус, Олимпийн бэлэгдэл бар нар хүрэлцэн ирсэн явдал байлаа. Бүтэн өдрийн турш Хүй долоон худагт хөгжилдөн цэнгэж тайзнаа хамтдаа флаш моби бүжиглэсэн үлгэрийн баатрууддаа хүүхдүүд сэтгэл хангалуун байж дурсгалын зургаа хамтдаа татуулж байсан юм.

“Монгол хүү -2019” хүүхдийн баяр нь Монгол үндэсний хэв шинж, маягийг агуулан хүүхэд багачуудад эрийн гурван наадам, үндэсний өв соёлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилготой байдаг бөгөөд энэхүү зорилгын хүрээнд энэ удаа Хүй

долоон худагт “Монгол хүү” гэрэл зургийн үзэсгэлэн, “Гийнгоо” түүхэн гэрэл зургийн үзэсгэлэнг бэлтгэн гаргасан юм.



Хүүхдийн гар зураг болон гэрэл зургийн үзэсгэлэнг бэлтгэн гаргасан

“Монгол хүү” хүүхдийн гар зураг болон гэрэл зургийн үзэсгэлэнг Монголын урлан бүтээх төвийн хүүхэд багачуудын бүтээлээр гаргасан бол “Гийнгоо морь унаач хүүхдийн түүхэн гэрэл зургийн үзэсгэлэнг ММСУХ-той хамтран 1922 оноос хойш Улсын баяр наадмын хурдан морьны уралдаанд хурдан морь унан түрүүлж, айрагдаж байсан хүүхдүүдийн түүхэн гэрэл зургаар гаргалаа. Мөн талбайд Махатма Гандигийн нэрэмжит Үйлдвэрлэл урлалын коллежийн багш, сурагчид ирсэн хүүхэд багачуудаар зураг зуруулан, хайчилбар наамал хийх анхан шатны мэдэгдэхүүн олгосон бол нөгөө талд 4 хүний бүрэлдэхүүнтэй зураач оюутнууд хүүхэд багачуудын нүүрэн дээр хүссэн үлгэрийн баатар, амьтдын дүрс зуран үйлчиллээ.



“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын зүгээс хүүхдийн баярын арга хэмжээнд оролцсон бүх хүүхдүүдийг өдрийн хоолоор дайлан, гарын бэлэг гардуулсан. Тус баярын арга хэмжээ нь ... цагаас эхлэн 17:30 минутад өндөрлөсөн. Нар хур тэгширсэн дэлгэр сайхан өдөр Хүй долоон худагт хүүхэд, багачууд маань баярын өдрөө өвөр дүүрэн бэлэгтэй, олон сайхан дурсамжтай өнгөрүүлж дараа жил дахин уулзахын ерөөл дэвшүүлэн сэтгэл хангалуун буцсан юм.

3.1.4 Айраг фестивалийг Хүй долоон худагт зохион байгууллаа.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-аас жил бүр зохион байгуулдаг “Айраг фестиваль-2019” наадмыг Монголын морин спорт уяачдын холбооноос зохион байгуулж буй “Их хурд VIII”-тай хамтран Хүй долоон худагт 2019 оны 7 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Уг арга хэмжээ нь үндэсний өв соёлыг дэлгэрүүлэн, ард иргэд болон жуулчдад Монголын уламжлалт цагаан идээ болох “Айраг”-ийг сурталчлан, танин мэдүүлэх зорилгын хүрээнд явагдсан.

Тус фестивалийн нээлтийн арга хэмжээ 2019 оны 7 дугаар сарын 21-ний өдөр “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дарга Д.Хатанбаатар, ММУСХ-ны дэд ерөнхийлөгч Пүрэвбаатар нар үг хэлж нээлтийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Айраг фестивалийн нээлтийн арга хэмжээнд нийтдээ 3000 гаруй үзэгч, оролцогчид цугласан. Уралдаан тэмцээнд оролцох хүсэлтэй нийтдээ 100 гаруй хүн бүртгүүлж үүнээс уралдаан, тэмцээнд амжилттай оролцсон 18 оролцогчийг шагнаж урамшуулав.

“Айраг фестиваль” арга хэмжээнд нийт зургаан төрлийн тэмцээн, уралдаан зохион байгуулсан. Үүнд:

- Дэмбээ
- Хэн сайн айраг уух вэ?
- Хамгийн сайхан айраг
- Хамгийн сайхан хөхүүр
- Найрын дууны аварга
- Чөдөр, ногт хэн сайн зангидах вэ? Зэрэг тэмцээн уралдааныг зохион байгуулсан.



Айраг фестивалийн асарт зочилсон зочид, ард иргэдийг айраг цагаалгаар дайлав.



“Айраг фестиваль”-ийн нээлтэд зориулж Үндэсний дуу бүжгийн эрдмийн театр ирж ая дуугаа өргөлөө.

“Айраг фестиваль”-ийн уралдаан, тэмцээнд оролцох хүсэлтэй иргэдийг бүртгэж тэмцээн уралдаанаа ийнхүү эхлүүлсэн юм.



Нэг. Хамгийн сайхан хөхүүр

Газар газраас ирсэн өөр өөрийн өв соёлыг агуулсан нийт 5 газрын хөхүүр бүртгүүлснээс хэрэглэгдэж ирсэн хөхүүрийн ур хийц, наслалтыг харгалзан, ялагчдыг шалгаруулав.

- 1-р байранд Төв аймгийн Баянхангай сумын өндөр настан Баасанжав,
- 2-р байранд Булган аймгийн Сайхан сумын иргэн А.Даваасүрэн,
- 3-р байранд Төв аймгийн Баян-өнжүүл сумын иргэн Н.Сарантунгалаг нарын хөхүүр шалгарсан.



Уралдаан тэмцээнд оролцож байгаа хөхүүр

Хоёр. Хамгийн сайхан айраг

Хамгийн сайхан айрагтай газрын уралдаанд нийт есөн аймгийн айраг оролцож

- 1-р байранд Булган аймгийн Могод сумын Б.Батсайханы айраг,
- 2-р байранд Булган аймгийн сайхан сумын А.Даваасүрэнгийн айраг

- 3-р байранд Архангай аймгийн хотон сумын Сараа нарын айраг шалгарсан



*Газар газраас ирсэн шилдэг есөн айргийг шүүгч нар амталж шалгаруулж байна
“Хамгийн сайхан айраг”-тай газраар шалгарсан иргэдийг шагнаж урамшуулав.*

Гурав. Хэн сайн айраг уух вэ?

Хэн сайн айраг уух вэ? Тэмцээнд нийт 20 оролцогч бүртгүүлж 30 секундэд хамгийн олон аяга айраг уусан оролцогчдыг шалгаруулах журмаар зохион байгууллаа.

- 1-р байранд Булган аймгийн Сайхан сумын иргэн А.Хишигжаргал,
- 2-р байранд Улаанбаатар хот Чингэлтэй дүүргийн иргэн М.Батмөнх,
- 3-р байранд Улаанбаатар хот Баянзүрх дүүргийн иргэн Э.Даваасүрэн нар шалгарсан.



“Хэн сайн айраг уух вэ?” уралдааны оролцогчид



“Хэн сайн айраг уух вэ?” уралдааны ялагчид

Дөрөв. Хамгийн сайн дэмбээчин

Хамгийн сайн дэмбээчин тэмцээнд нийт 42 хүн бүртгүүлж оролцсоноос

- 1-р байранд Төв аймгийн Бүрэн сумын иргэн Ж.Найдалмаа,
- 2-р байранд Дундговь аймгийн Эрдэнэцогт сумын иргэн Л.Сунгарав,
- 3-р байранд Өвөрхангай аймгийн Баян-өндөр сумын иргэн Т.Батзаяа нар шалгарсан.



“Дэмбээ”-ний тэмцээн



“Дэмбээ” тэмцээний ялагчид шагнал гардуулах ёслол

Тав. Найрын дууны аварга

Найрын дууны аварга шалгаруулах тэмцээнд нийт 20 оролцогч оролцсоноос

- 1-р байранд Говьсүмбэр аймгийн өндөр настан Г.Арилд,
- 2-р байранд Төв аймгийн Алтанбулаг сумын иргэн Хэнмэдэх,

- 3-р байранд Говь сүмбэр аймгийн иргэн Д.Самданбазар нар тэргүүлсэн.



“Найрын дууны аварга” тэмцээний оролцогчид



“Найрын дууны аварга” тэмцээний ялагчид

Зургаа. Чөдөр, ногт хэн сайн зангидах вэ?

Чөдөр, ногт хэн сайн зангидах вэ? тэмцээнд нийтдээ арван таван аймгийн уяачид бүртгүүлж хэн нь уран чадварлаг чөдөр ногт зангидах вэ? хэмээн ур чадварыг сорьсон тэмцээн болж өндөрлөсөн.

- 1-р байранд Өвөрхангай аймгийн Хайрхан дулаан багийн иргэн Ж.Шаравдорж
- 2-р байранд Архангай аймгийн Эрдэнэбүрэн сумын иргэн А.Баярмагнай
- 3-р байранд Булган аймгийн Б.Даваасүрэн нар тэргүүллээ



Үр дүн

Ийнхүү айраг фестивалийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа тэмцээн уралдаан маань олон нийтийг хамарч үзэгч олныг баясгаж чадсан наадам болж өндөрлөлөө. Айраг фестиваль нь Монгол орны хөхүүрийн айрагны соёлыг түгээгч өвлөн уламжлагч түүнийг шимтэн уух дуртай “айраганд дурлагсад”-ын талархлыг хүлээсэн баяр болоод байгаа билээ. Айраг фестивалиар дамжуулан хөхүүрийн айрагны онцлог ач холбогдол, хөхүүрийн айрагтай холбоотой зан үйлийг сурталчлах томоохон индэр болж буй юм. Айраг фестивалийн үр дүнд хөдөө орон нутгийн амьдралаас хол байдаг нийслэл хотын залуус болон жуулчдад хөхүүрийн айраг түүнтэй холбогдох зан үйл мөн монгол уламжлалт идээ будааг таниулах зорилгоор “Айраг фестиваль”-ийг зохион байгуулсан нь ийнхүү үр дүнтэй болж өндөрлөлөө.

3.1.5 “Морь уналга, сургалт”-ын төвийг нээн ажиллуулаа.

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ нь Хүй долоон худгийг жилийн дөрвөн улирлын турш тогтмол үйл ажиллагаатай болгох, үндэсний спорт, соёл, аялал жуулчлалын бүс болгохоор зорин ажиллаж байгаа билээ. Энэ зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй Хүй долоон худагт хүүхэд залуучуудад зориулан “Морь уналга, сургалт”-ын төвийг 2019 оны 06 дугаар сар 20-ний өдрөөс эхлэн нээн ажиллуулж 2019 оны 07 дугаар сарын 20-ний өдрийг хүртэлх хугацаанд ажлууллаа. Энэхүү сургалтын төвөөр үйлчлүүлсэн хүмүүсээ давхацсан тоогоор тооцож үзвэл энэ хугацаанд нийт 18 байгууллагын 700 гаруй орчим Нийслэлийн хүүхэд залуучуудад үйлчилсэн байна.

Морь уналга, сургалтын төвийн талбайн тохижилтын хувьд:

Энэхүү сургалтын төвөөр амарч тухлах таатай орчинг бүрдүүлэх үүднээс “Грийт тоур” ХХК-тай захиалгаар ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 4.400.000 төгрөг үнэ бүхий хоёр сүүдрэвчийг хийлгэсэн.



Захиалгаар хийлгэсэн модон сүүдрэвч



Сургалтын төвийн тохижилтын байдал

“Элст мянган констракшн” ХХК-тай гэрээ байгуулан 8.056.000 төгрөгний өртөгтэй ажиллуудыг хийсэн. Үүнд:

Хашааны тохижилтын ажлын хувьд:

- ❖ 3 метр өндөр шонтой гэрэл 8 ширхэг
- ❖ 60см өндөр явган гэрэлтүүлгүүд
- ❖ Төмөр шон 4 ширхэг
- ❖ 15 метр урт морины уяаны олс
- ❖ Хашаан доторх талбайн 0,9 га газрын хөрсийг тэгшилж, засч зүлэгжүүлсэн



Сургалтын төвийн тохижилтын ажил

Морь уналга, сургалтын төвийн тохижилтонд морьд уях дөрвөн төмөр шон, 15 метр урт морины уяаны олс, хашаан доторх талбайн 0,9 га газрын хөрсийг тэгшилж зам засаж зүлэгжүүлэн, бусад жижиг хэрэгсэл болох хазаар, ногт, тохом, эмээл, дөрөө гэх мэт зүйлүүдийг бэлдэж бэлэн болгосон.



Морь уналга, сургалтын төвийн үндсэн үйл ажиллагааг тогтмолжуулах үүднээс “Мазаалай эксплор” ХХК-тай 21 хоногийн хугацаанд иж бүрэн уналгын хэрэгсэлтэй 10 морьдыг 5.040.000 төгрөгөөр түрээслэх гэрээ байгуулан хамтран ажиллаа.

Морь уналга, сургалтын төвөөр үйлчлүүлсэн байдал:

Энэхүү морь уналга, сургалтын төв нь Нийслэлийн хүүхэд залуусын амралт, чөлөөт цагийг эрүүл цэнгэг агаарт зөв боловсон өнгөрүүлэхийн зэрэгцээ адууны уналга, эдэлгээний соёлыг монгол түмэндээ төдийгүй гадаадын зочид жуулчдад түгээн дэлгэрүүлэх үйлсийн эхлэл болж байгаа юм. “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ бэлтгэл ажлыг бүрэн дүүрэн хангаж 2019 оны 06 дугаар сарын 20-ний өдрөөс үйл ажилгаагаа эхлүүлж 10 дугаар сарын 13-ний өдөр хүртэлх хуцагаанд ажиллуулаа.



Морь уналга, сургалтын төвөөр үйлчлүүлсэн хүүхдүүд



Анх удаагаа морь унаж буй байдал

Тус төв нь энэ жилийн хувьд 10 морьтойгоор үйл ажиллагаагаа эхлүүлэн Дотоод болон сурагчдын аялал зохион байгуулдаг албан ёсны эрхтэй “Хурд фото тур” ХХК, Аха тур ХХК, “Монгол туургатан” ХХК, Старт трэйвел” ХХК, “Зуун зам” ХХК зэрэг компаниудтай хамтран нийслэлийн ерөнхий боловсролын Чингэлтэй дүүргийн 5, 37, 39, Хан-Уул дүүргийн 18, Баянгол дүүргийн 51, 73, Баянзүрх дүүргийн 102, Сонгинохайрхан дүүргийн 62, 65, 102, 105, 123, 124 дүгээр сургуулиудын нийт 560 орчим хүүхдүүд, Мөн Тольт, Олонлог, Хобби, Хишиг, Ертөнц, Номуун зэрэг хувийн сургуулиуд анги болон бүлэг байдлаар хамрагдсан.

Манай сургалтын төвөөр улсын ерөнхий боловсролын 13 сургууль, хувийн 6 сургууль, бусад хувь хүн гэр бүл, найз нөхөд гээд 200 орчим хүмүүс үйлчилгээ авсан байна. Нийт энэхүү сургалтын төвөөр үйлчлүүлсэн хүүхэд, залуучууд, бусад хүмүүсээ давхацсан тоогоор тооцож үзвэл 760 гаруй орчим хүнд үйлчилсэн байна. Морь уналга, сургалтын төвийн үйл ажилгааг жилээс жилд өргөжүүлэн цар хүрээг нь нэмэгдүүлж Нийслэлийн иргэд, хүүхэд залуучуудад хүргэх зорилгоор дүүргүүдийн ерөнхий боловсролын сургуулийн бага, ахлах ангийн сурагчдыг идэвхтэй хамруулах хөтөлбөр арга хэмжээг боловсруулан ирэх оны төлөвлөгөөнд тусган ажиллана.

3.2 Хүний нөөцийн талаар

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын хүний нөөцийг чадавхижуулах “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг газрын даргын 2017 оны 8 дугаар сарын 1-ны өдрийн А/40 тоот тушаалаар баталсан бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс жил бүрийн төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. 2019 оны байдлаар “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын 24 албан хаагч шинээр томилогдон 21 албан хаагч чөлөөлөгдсөн байна.

1. Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байдал:

Сул орон тооны зарыг тухай бүр байгууллагын дотоод мэдээллийн самбар болон байгууллагын албан ёсны www.mnts.ub.gov.mn цахим хуудсанд тухай бүр шинэчлэн олон нийтэд нээлттэй ажлын зарыг хүргэж байна. Сул орон тооны зарыг 2019 оны

12 дугаар сарын 23-ны өдөр шинэчлэн Сантехникчийн 1 сул орон тооны зарыг www.mnts.ub.gov.mn цахим хуудсанд шинэчлэн байршуулсан.

2. Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчилсэн байдал:

Газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 20-ы өдрийн А/14 дугаар тоот тушаалаар батлагдсан Ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг нийт ажилтан, албан хаагчид өдөр тутамдаа мөрдөн ажиллаж тухайлсан журмыг нээлттэйгээр байгууллагын албан ёсны сайт болон дотоод мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна.

3. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчилсэн байдал: Хүний нөөцийн ил тод байдлыг хангах зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Байгууллагын цахим хуудас www.mnts.ub.gov.mn – нд хуулиар хориглоогүй мэдээллийг ойлгомжтой байдлаар байршуулсан. Үүнд:

1. Байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр
2. Ажлын байрны нээлттэй зар
3. Байгууллагын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам
4. Байгууллагын бүтэц, зохион байгуулалт
5. Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар
6. Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт
7. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээлэл зэргийг нээлттэйгээр өдөр тутам шинэчлэн цахим хуудсанд байршуулж байна.

4. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байдал:

Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр өөрийн цахим хуудсандаа дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Цаг тухай бүрд сул орон тоог зарлах
2. Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль, тогтоомж, дүрэм, журам, заавар
3. Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт зэргийг бусад хуулиар хориглоогүй мэдээ мэдээллийг ил тод байдлаар шинэчлэн мэдээлж байна.

5. Албан ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байдал:

Газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/08 дугаар тушаалаар байгууллагын ажилчдын ур чадварын нэмэгдэл олгох ажлын хэсэг болон журмыг шинэчлэн баталсан. Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 4 дүгээр хавсралтыг хэрэгжүүлэн ажилтнуудын ажлын үр дүнг дүгнэж ур

чадварын нэмэгдлийг олгож байна. /Хүний нөөцийн ил тод байдлын тайланг хавсаргав. 3-р хавсралт/

3.3 Өргөдөл, гомдлын талаар

Хүний нөөцийн асуудлаар санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч барагдуулахад дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд Хүний нөөцийн холбогдол бүхий нийт 196 өргөдлийг хүлээн авч бүртгэж холбогдох хууль тогтоомжийн дагуу шилжүүлэв. Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын захиргаа, санхүүгийн алба, маркетингийн албаны албан хаагчид өргөдөл, гомдлын нэгдсэн цахим систем болох egr.ulaanbaatar.mn сайтыг өдөр бүр тогтмол шалгадаг бөгөөд байгууллагын хэмжээнд иргэдээс ирүүлсэн гомдол, санал, хүсэлт байхгүй бөгөөд байгууллагын дотоод асуудлаар ажилтнуудын хандсан өргөдөл, хүсэлтийг хуулиар тогтоосон хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна. 2019 онд нийт 196 өргөдөл, гомдол бүртгэгдсэнээс:

1. Цалинтай чөлөө хүсэх тухай 3
2. Ажлаас чөлөөлөгдөх тухай 23
3. Ажилд томилогдох тухай хүсэлт 23
4. Ажилд шилжүүлэн томилогдох тухай хүсэлт 10
5. Ээлжийн амралт хүсэх тухай 29
6. Хуушуур худалдаалах болон соёлын талбайн түрээсийн тухай хүсэлт нийт 108 бүртгэгдсэн байна.

Эдгээр өргөдлийн шийдвэрлэх хугацаандаа Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллаагүйн улмаас нийт 99 өргөдөл гомдолд 397 зөрчил тооцогдоод байна. Үүнээс хугацаандаа буюу ажлын 8 цагийн хугацаандаа шийдвэрлээгүй 376 зөрчил, 10 хоногийн хугацаанд тэмдэглэл хөтлөөгүй 21 зөрчил илрээд байна. Энэ зөрчлийн дагуу Нийслэлийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 10/4290 тоот албан бичгээр 115 тоот зөвлөмж ирүүлсний дагуу даргын зөвлөлийн хуралд танилцуулж холбогдох арга хэмжээ авахыг сануулсан. Энэхүү зөвлөмжийн дагуу даргын зөвлөлийн хурлаас холбогдох албан тушаалтнуудад сануулах арга хэмжээг авч ажилласан.

3.4 Архивын бичиг хэргийн талаар

Нэг. Албан хэрэг хөтлөлтийн ажлын талаар:

1. Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар” “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт” MNS5140:1:2011, MNS5140:2:2011, MNS5140:3:2011-ын дагуу хөтлөх хэргийн нэгдсэн дугаар олгох, бүртгэн шилжүүлэх ажилд хяналт тавьж ажилласан.

Архив, бичиг хэргийн ажилтныг байгууллагын төсвөөс сургалтын төлбөрийг нь гарган МАОЭНХолбооны архивын сургалтад хамруулж сертификат авсан ба Нийслэлийн архивын газраас зохион байгуулагдсан цаг үеийн шинж чанартай

мэргэжил, арга зүйн сургалтуудад тухай бүр хамруулан чадавхижуулах арга хэмжээг авч ажилласан.

2. Байгууллагад нийт гаднаас ирсэн 236 албан бичгийг edoc.ub.gov.mn архив, албан хэрэг хөтлөлтийн программд бүртгэж, удирдлагад шилжүүлсэн бөгөөд байгууллагаас гадагш 266 албан бичиг явсан болно. Байгууллагын явуулж буй бүх бичгийн стандартыг шалган дугаарлаж, албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системд бүртгэж ажилласан. Байгууллагын ажилтан, албан хаагчдын боловсруулсан албан бичгийг холбогдох байгууллагад хүргүүлэх. Явуулсан баримт бичгийн үлдэх хувийг нь ангилан төрөлжүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.

Дээд газраас ирсэн тогтоол, шийдвэрийн 2019 онд 4 тогтоол ирснийг бүртгэсэн. Шийдвэрлэлтийн тайлан, мэдээг хагас болон бүтэн жилээр гарган тайлагнан ажилладаг шийдвэрлэлт 100 хувь байна.

2019 оны байдлаар 1 бичиг хугацаа хэтэрч шийдвэрлэсэн.

Хэвлэмэл хуудасны эхийг хянуулж стандартын дагуу хэвлүүлэхээр албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн “Edoc” системээр дамжуулан 2019 онд 3 удаа захиалга өгсөн.

Архивын Ерөнхий газрын 2016 оны А/142 дугаар тушаалаар батлагдсан “Хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх хадгалах журам”-ын 4.4-д заасны дагуу хэвлэмэл хуудсыг ангилан төрөлжүүлж, индексжүүлсэн 2019 оноос тус журмын 3 болон 5 дугаар хавсралтын дагуу бүртгэл хөтлөн, зарцуулалтын мэдээ гаргаж тайлагнаж ажилласан.

Байгууллагын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах комиссын үйл ажиллагаа тогтмолжсон. Он тус бүрд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын ББНШК-ын хурлаар хэлэлцүүлэн баталж, Нийслэлийн Архивын дэргэдэх ББНШАЗК-ын 2018 оны 12 дугаар сарын 11-ний 5 дугаар хурлаар оруулан батлуулсан.

Нийт ажилтан, албан хаагчид шуурхай хуралдааны үүрэг даалгаврын биелэлтийг гарган, хяналт тавин ажиллаж байна.

Байгууллагын НАГ-ын салбар комисс улсын үзлэгийг явуулж албан, хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд 92.9/А/ үнэлгээ авсан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан нийслэлийн хэмжээнд улсын үзлэг явуулах хуваарийг тус тус үндэслэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга А. Даваажаргал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Г. Насанжаргал, Нийслэлийн Архивын газрын Мэргэжлийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Б.Энхбаяр, Нийслэлийн Архивын газрын Лавлагаа үйлчилгээний хэлтсийн Архивч Ц.Цаст-Ундарга нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ын төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд улсын үзлэг явуулсан.

Хоёр:Архивын үйл ажиллагааны талаар

2.1 Байгууллагын удирдлагаас архивын талаар авсан арга хэмжээ, үр дүн:

Архивын ажлыг тусад нь төлөвлөж, биелэлтийг гаргаж хэвших гэж байгаа, А/633 дугаар хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2.2 Байгууллагын архивд баримт шилжүүлэх, хүлээн авах үйл ажиллагаа:

Байгууллагын архивын нөхөн бүрдүүлэлтийн ажлыг 2018 оноос эхлэн төлөвлөн ажиллаж зохион байгуулалтын нэгж ажилтнуудаас ХХНЖ-ын дагуу удирдлагын болон тусгай төрлийн баримтыг байгууллагын архивт хуваарийн дагуу хүлээн авч, архивын сан хөмрөгийг нөхөн бүрдүүлж хэвшсэн. Үүнд

2013-2018 оны байнга хадгалах 181 хадгаламжийн нэгж

2013-2018 оны түр хадгалах 188 хадгаламжийн нэгж

2013-2018 оны 28 хадгаламжийн нэгжийг хүлээн авч эмхлэн цэгцэлж данс бүртгэлд оруулсан.

Нөхөн бүрдүүлэх ажлыг хугацаанд нь хийж хэвшсэн.

Архивын баримтын тоо бүртгэл

Байгууллагын архивд хөтлөгдөх тоо бүртгэлийн үндсэн болон туслах баримт бичгийг зааврын дагуу хөтөлж АЕГ-ын даргын 2018 оны А/97 дугаар тушаалаар батлагдсан “Архивын баримтад нэгдсэн тоо бүртгэл хөтлөх журам”-ын дагуу байгууллагын архивын баримтын тоо хэмжээ, хадгалалтын мэдээ нь байгууллагын данс бүртгэлд тусгагдсан.

Архив нь нэг хадгаламжийн сантай, архивын баримтыг хадгаламжийн санд зааврын дагуу байрлуулсан.

Хадгаламжийн сангийн чийг дулааны бүртгэл, цэвэрлэгээний бүртгэлийг хийж хадгаламжийн санд ариутгалыг 7 хоногт 2 удаа хийдэг.

Тус байгууллага иргэдийн хүсэлтийн дагуу архивын лавлагаа, хуулбарыг олгож, зааврын дагуу бүртгэл хөтлөн ажилласан.

Байгууллагад НАГ-ын салбар комисс улсын үзлэгийг явуулж архивын үйл ажиллагаанд 88/В/ үнэлгээ авсан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан нийслэлийн хэмжээнд улсын үзлэг явуулах хуваарийг тус тус үндэслэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга А. Даваажаргал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Г. Насанжаргал, Нийслэлийн Архивын газрын Мэргэжлийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Б.Энхбаяр, Нийслэлийн Архивын газрын Лавлагаа үйлчилгээний хэлтсийн Архивч Ц.Цаст-Ундарга нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ын төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд улсын үзлэг явуулсан. Энэхүү улсын үзлэгт нэгдсэн дүнгээр 86,7 хувийн үзүүлэлттэй дүгнэгдэн ажиллаж байна.

Архив албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх цахим сан бүрдүүлэн ажиллаж байна. Архив, бичиг хэргийн ажилтнууд Архивын Ерөнхий газар, Нийслэлийн Архивыг газар, НЗДТГ-аас зохион байгуулсан мэдээлэл технологийн сургалтад хамрагдсан. Байгууллагын хэмжээнд ашиглаж буй

хэрэглээний программын ном, гарын авлага, мэдээлэл технологийн дүрэм, журам, хууль, судалгааг гаргасан.

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”, Засгийн газрын 2019 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах журам”, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт” зэрэг хууль, журмыг ханган ажилласан. Нийслэлийн Засаг даргын тамгын газрын 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 10/5527 тоот албан бичгээр “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын цахим хуудасны мэдээллийн ил тод байдалд үнэлгээ хийсэн зөвлөмжийг ирүүлсэн бөгөөд 2019 онд 73 хувьтайгаар дүгнэгдсэн. Зөвлөмжийн дагуу ажил сайжруулах төлөвлөгөө боловсруулан газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. /”Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын мэдээллийн ил тод байдлын тайланг хавсаргав. 4-р хавсралт/

ТАВ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

“Халх голын 80-н жил”-ийн ойн арга хэмжээний хүрээнд зориулан “байлдааны нисэх онгоцны үзүүлэх тоглолт” хүй долоон худагт зохион байгуулагдлаа

Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 210 дугаар тогтоолын дагуу Нийслэлийн Засаг даргын 2019 оны 04-р сарын 22-ны өдрийн А/350 тоот захирамжаар Улаанбаатар хотын хэмжээнд Халх голын байлдааны ялалтыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд байлдааны онгоцны үзүүлэх тоглолт 2019 оны 8 дугаар сарын 28-ны өдөр Хүй долоон худагт болж өндөрлөлөө.



Хүй долоон худагт болсон байлдааны онгоцны үзүүлэх тоглолт

Уг үзүүлэх тоглолтын үеэр ОХУ-ын Агаар-сансарын хүчний гвардын 234 дүгээр нисэх хорооны Су-30СМ загварын байлдааны дөрвөн онгоцноос бүрдсэн “Русские витязи” багийн уран нислэгийн үзүүлбэр болж Хүй долоон худагт цугларсан олныг баясгасан юм. Үзүүлэх тоглолтыг Монгол Улсын Ерөнхийлөгч Зэвсэгт Хүчний Ерөнхийлөгч Командлагч Х.Баттулга, ОХУ-ын Зэвсэгт хүчний жанжин штабын орлогч дарга дэслэгч генерал А.Ю Чайко, Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан, Агаарын цэргийн штабын дарга Бригадын генерал Б.Батбаяр тэргүүтэй зочид төлөөлөгчид ирж үзэж сонирхсон юм.



Мөн үзүүлэх тоглолтын үер Алдар спорт хорооноос “Бэсрэг” наадам зохион байгуулан Хүй долоон худгийн Соёл, урлагийн талбай дээр 64 хүчит бөхийн барилдаан, шагайн харваа, хурдан морины уралдаан, урлагийн тоглолт зохион байгуулагдсан.

Энэхүү онгоцны үзүүлэх тоглолт болон “Бэсрэг” наадмын үеэр иргэдэд үйлчлэх эко автобус болон талбайн хог цэвэрлэгээ, нийтийн бие засах газрын үйлчилгээний ажлыг “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ бүрэн хариуцан ажиллаа. Тус ажлыг хийж гүйцэтгэхдээ талбайн хог цэвэрлэгээг хийж гүйцэтгэх, тээвэрлэн асгах болон эко автобус жолоодох ажлыг “Мандах райзинг” ХХК-тай 2,858,400 төгрөгний МНЦ 19/167 тоот гэрээ байгуулан, нийтийн бие засах газарт цэвэр ус нийлүүлэх, бохирыг сорж асгах, цэвэрлэгээ үйлчилгээг хийж гүйцэтгэх ажлыг “Мөнхийн амьд ус” ХХК-тай 4,000,000 төгрөгний МНЦ 19/166 тоот гэрээг тус тус байгуулан хамтран ажиллаа.

Тохижилт, үйлчилгээний чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын хувьд:

- Наадмын талбайн зохион байгуулалтад НЗАА-ны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэстэй хамтран хуушуурын зөвшөөрөл 2 газар, кофе шоп 1 газар, зайрмаг 1 газар буюу нийт 4 цэгт зөвшөөрөл олгож талбайг хуваарилан, аюулгүй ажиллагааг ханган зааварчилгаа өгч хамтран ажиллаа.
- “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-аас иргэдэд үйлчлэх экобус 15 ширхэг, контнейрэн нойл 5 ширхэг, үзэгчдийн сандал 600 ширхэг, монгол

асар 5 ширхэг, төмөр хогийн сав 20 ширхэг, иж бүрэн тайз карказ, хөгжим, лед дэлгэц угсарч байршуулан ажиллагааг 100% хариуцан ажиллаа.

- “Мандах райзинг” ХХК нь морь барианы газар түүний эргэн тойрон болон Соёл, урлагийн талбайн хог цэвэрлэгээг наадмын өмнө болон дараа нь 20 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр цэвэрлэн хүлээлгэн өгсөн. Гарсан хог хаягдлын хогийн цэгрүү автомашинаар 2 удаагийн рэйсээр тээвэрлэн асгасан. Мөн экоавтобус барих тусгай зориулалтын Д ангилалын жолооны үнэмлэхтэй 15 жолооч болон 1 механик инженер ажиллуулан талбайд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлсэн.
- “Мөнхийн амьд ус” ХХК нь талбайд байрлалтай 5 ширхэг нийтийн бие засах газарт 2 усны автомашинаар 15 удаагийн рэйсээр нийт 200 тн цэвэр ус нийлүүлж, 300 тн бохир ус соруулан цэвэрлэх байгууламжийн бохирын цооногт зөөвөрлөсөн.

Талбайн тохижилт, эко автобусны үйлчилгээ, нийтийн бие засах газрын ажиллагаа, цэвэрлэгээ, үйлчилгээ болон хөгжим, лед дэлгэцийн хэвийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж байх хугацаанд ямар нэгэн гэмтэл, доголдол, саатал гараагүй бөгөөд үзэгч олон сэтгэл хангалуун байлаа.

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ “Монголын хөнгөн атлетикийн холбоо” ТББ-тай хамтран ажиллах санамж бичиг байгууллаа.

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ нь “Монголын хөнгөн атлетикийн холбоо” ТББ-тай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурах үйл ажиллагаа Спортын төв ордонд 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдөр боллоо. Уг санамж бичигт “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ыг төлөөлж дарга Д.Хатанбаатар “Монголын хөнгөн атлетикийн холбоо” ТББ-г төлөөлж ерөнхий нарийн бичгийн дарга Ч.Зоригтбаатар нар гарын үсэг зурсан юм.

Хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурах үйл ажиллагаанд STAR телевиз, MNB спорт сувгийн сурвалжлагч нар болон Setguulch.mn, Taamag.mn портал сайтуудын сэтгүүлч нар ирж сурвалжлага хийн ярилцлага авсан юм. Энэхүү санамж бичгийн гол зорилго нь Хүй долоон худагт 2019 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр “Тал нутгийн монгол” Олон улсын марафон гүйлтийн тэмцээнийг хамтран зохион байгуулах болон бусад спортын уралдаан тэмцээн, бүх нийтийн арга хэмжээг зохион байгуулахад хамтран ажиллах, хоорондын ажлын уялдаа холбоог хангаж харилцан дэмжлэг үзүүлж үйл ажиллагааны бодит үр дүнд хүрэхэд оршиж байгаа юм.

Г.Пунцагбалжир агсны нэрэмжит “Төвийн бүсийн хурдан морины уралдаан”-ыг Хүй долоон худаг-т зохион байгууллаа

“Монгол Наадам Цогцолбор” ОНӨТҮГ нь Г.Пунцагбалжир агсны нэрэмжит “Төвийн бүсийн хурдан морины уралдаан” наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх талаар 28 төрлийн ажлууд төлөвлөн Наадмын ажлын хэсгийн гишүүнээр “Монгол Наадам Цогцолбор” ОНӨТҮГ-ийн дарга Д.Хатанбаатар, Ерөнхий зохион байгуулагчаар байгууллагын орлогч дарга Р.Дашгомбо нар томилогдон ажиллаа. Тус ажлыг зохион байгуулахад манай байгууллагын Захиргаа, Санхүүгийн алба, Маркетингийн алба,

тохижилт, үйлчилгээний албаны нийт 37 ажилтан ажиллаж тохижилт, засвар үйлчилгээ, зохион байгуулалтын ажлыг гаргасан төлөвлөгөөний дагуу тогтоосон хугацаанд амжилттай хийж гүйцэтгэлээ.



Уралдааны зохион байгуулалтын бэлтгэл ажлын 14 хоногийн хугацаанд ММСУХ-той нийт 4 удаа, байгууллага дотооддоо нийт 3 удаа хуралдаж Маркетингийн хэлтсээс гаргасан 28 зүйл бүхий ажлын төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн ажлуудыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэн, гэрээт байгууллагуудаас гүйцэтгэлээ шаардан хяналт тавьж, тулгамдсан асуудлуудыг цаг тухайд нь шийдвэрлэж ажиллаа. Төвийн бүсийн хурдан морины уралдааныг зохион байгуулах ажлын хэсэг “Хүй долоон худаг”-т 2 удаа хуралдан талбайн тохижилт үйлчилгээнд үзлэг шалгалт хийж, морины зам засалт, морины замын усалгаа, шүдлэх морины хашаа, коммисын хашааны тохижилтын талаар шинэ санал, санаачилга гарган ярилцаж газар дээр нь асуудлуудыг шийдвэрлэж байсан юм.

5.1.3 “Шигшмэл хурдан морьдын их хурд-8” Монгол туургатны морьтны өв соёлын наадмыг Хүй долоон худагт зохион байгууллаа.

“Шигшмэл хурдан морьдын Их хурд-8”, Монгол туургатны морьтны өв соёлын наадмыг “Хүй долоон худаг”-т 2019 оны 07 дугаар сарын 20, 21-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус наадмыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг “ММСУХ” ТББ-ын хүсэлт болон удирдлагын өгсөн чиглэлийн дагуу 25 зүйлтэйгээр боловсруулан “Монгол Наадам Цогцолбор” ОНӨТҮГ-ын нийт 37 ажилтан Хүй долоон худаг дахь тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний зохион байгуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу тогтоосон хугацаанд амжилттай хийж гүйцэтгэлээ. Байгууллагын баг бүрэлдэхүүн нь “Их хурд-8” наадмын зохион байгуулалтын бэлтгэл ажлыг 07 дугаар сарын 15-ны өдрөөс эхлүүлж төлөвлөгөөний дагуу талбайн тохижилт, засвар үйлчилгээг цаг хугацаанд нь хийж ажилласан. Нийт бэлтгэл ажлын хугацаанд “ММСУХ” ТББ-тай 4 удаа, хамт олны болон удирдлагын түвшинд 3 удаа хуралдаж төлөвлөгөөний гүйцэтгэл, чанарын хэрэгжилтэд хяналт тавин, үйлчилгээ үзүүлэх байгууллагуудтай гэрээ байгуулан ажлыг хийж гүйцэтгүүлэн үр дүнг хянан, тулгамдсан асуудлуудыг цаг тухай бүрд нь шийдвэрлэн ажилласан.

“Шигшмэл хурдан морьдын Их хурд-8”, Монгол туургатны морьтны өв соёлын наадмын төсвийг “ММСУХ” ТББ-тай тохиролцон 34,596,647 төгрөгөөр батласан. Дээрх төсвийн түрээсийн зардал нь 13,260,000 төгрөг, тохижилт, засвар үйлчилгээ,

үйл ажиллагааны зардал нь 21,336,647 төгрөг байсан. Гэвч Нийслэлийн ЗДТГ нь Их хурд наадмыг ММСУХ-той хамтран зохион байгуулж “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-т төлөгдөх түрээсийг орлогыг авахгүй байх шийдвэрийг НЗДТГ гаргасан юм.

Тохижилт, засвар үйлчилгээ, үйл ажиллагааны төсөвт ажлууд дараах чиглэлтэй байв. Үүнд:

6. Нойлуудад цэвэр ус нийлүүлэх зардал /2 өдрөөр/
7. Нойлуудаас бохир ус соруулан асгах зардал /2 өдрөөр/
8. Талбайн хог цэвэрлэгээ, нойлуудын засвар үйлчилгээ, бусад туслах материалын зардал /2 өдрөөр/
9. Эко автобус барих жолоочийн зардал /2 өдрөөр/
10. Тайзны хөгжим, лед дэлгэц, гэрэл ажиллуулах зардал /2 өдрөөр/
11. Үзэгчдийн сандал, тайз хөгжим, майхан угсрах, хураах шатахууны зардал
12. Цахилгааны зардал /2 өдрөөр/

НЭГ. Тохижилтын чиглэлээр хийсэн ажлууд:

Хүй долоон худгийн морь барианы хэсэг болон хүнс, худалдаа үйлчилгээний зам талбайд усалгаа, цэвэрлэгээ, хог тээврийн үйлчилгээ, цэвэр ус нийлүүлэх, бохир соруулалт, хогийн сав байрлуулах, сандал угсрах, контейнрэн нойл засварлах, ерөнхий зохион байгуулалтыг хариуцан хийж гүйцэтгэх ажилд “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын 37 ажилтан, эко автобус барих 27 ажилтан, нойлуудад цэвэр ус нийлүүлэх, бохир соруулах 14 ажилтан, тайз хөгжим хариуцан ажиллуулах 3 ажилтан, байгууллагын 11 автомашин, техник, гэрээт байгууллагаас 10 автомашин, техник, 25 экоавтобус гарч ажилласан.

- Хүй долоон худгийн морь барианы газарт 1500 үзэгчдийн зөөврийн суудал, хүнс, худалдаа үйлчилгээний талбайд 1000 зөөврийн суудал байршуулан “Их хурд-8” наадамд хүрэлцэн ирсэн наадамчин олны хурдан морины уралдаан үзэх, бусад тайзны арга хэмжээг үзэх тав тухыг хангасан.
- Наадмын талбайд хуучин 9 байршилд контейнерэн бие засах цэгүүдийг засварлан, цэвэрлэгээ үйлчилгээг хийн ажилласан.
- Талбайд шүдлэх морины хашаа, комиссын хашаа, зурхайн хашааг байршуулсан.
- Наадмын өдрүүдээр автобусны зогсоолоос А,Б зогсоол хүртэлх 2,7 км замд нийт 25 ширхэг эко автобусаар 27 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллан наадамчдад үйлчилсэн.
- Морь барианы газар түүний эргэн тойрон, комиссын хашаа, түүний эргэн тойронд 2 усалгааны автомашинаар наадмын 2 өдөр 6 удаагийн рэйсээр 60тн усалгаа хийсэн.
- Комиссын нойлын цэвэрлэгээ, үйлчилгээг 2 өдрийн турш хариуцан ажилласан.
- Хүй долоон худгийн радио үзелийг 2 хоногийн турш ажиллуулан хурдан морины уралдаан болон наадамчин олонд зориулсан зарлал, мэдээ, мэдээлэл, цаг агаарын мэдээг цаг тухай бүр нь дамжуулсан.
- Баяр наадмын талбайн хог цэвэрлэгээг “Суман хас” ХХК-тай хамтран хийж 07 дугаар сарын 18-ны өдөр талбайд урьдчилсан цэвэрлэгээ, 07 дугаар сарын

20-оос 21-нд шилжих шөнө болон үүрээр, 07 дугаар сарын 22-ны өдөр хаалтын цэвэрлэгээг тус тус хийн хогны машинаар тээвэрлэн асгаж “Их хурд-8” наадмын талбайд хоггүй цэвэр, цэмцгэр байлгах тал дээр анхаарч ажилласан.

- Талбайд нийт 40 ширхэг хогийн сав байршуулан 2 өдрийн турш хогийн савнуудыг султган хогийг ачин тээвэрлэж ажилласан.
- Морь барианы газарт 4*6 хэмжээтэй тайз, 3*6 хэмжээтэй лед дэлгэц байршуулан үйл ажиллагааг 2 өдөр хариуцан ажилласан.
- Хүнсний талбайд 4 ширхэг монгол асар, солонгос майхан 8 ширхэгийг тус тус байршуулан бөхийн барилдаан, лам нарын сууж ном унших хэсэг зэргийг тохижуулан ажилласан.
- 7 дугаар сарын 21-ний өдөр Морь барианаас баруун тийш 50 м газарт монгол майхан 1ш, үзэгчдийн сандал, хөгжим байршуулан “Уран уурагч, бугуйлч шалгаруулах тэмцээ”-ний тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.
- Аюулгүйн тойрог болон морь барианы төв индэрт “ММСУХ” ТББ-ын тугнуудыг байршуулан, зам дагуух сурталчилгааны самбаруудад холбооны болон наадмын мэндчилгээг байршуулан ажиллаа.



“Их хурд- 8” наадмын нээлтийн арга хэмжээ

ХОЁР: “Их хурд-8” наадмын төсөвт ажлууд:

Хүй долоон худаг дахь морь барианы газрын контейнерэн нийтийн бие засах газруудыг цэвэр усаар хангах ажил /9 ширхэг/

Хүй долоон худагт 2019 оны 7 дугаар сарын 20, 21-ны өдрийг дуустал наадамчдад үйлчлэх нийтийн бие засах газруудыг цэвэр усаар хангах ажлыг 4,650,000 төгрөгөөр баталсан. Батлагдсан төсвийн хүрээнд “Мөнхийн амьд ус” ХХК-тай 2019 оны 07 дугаар сарын 19-ны өдөр МНЦ 19/158 тоот гэрээ байгуулан ажилласан. Тус байгууллага нь Хүй долоон худаг дахь морь барианы газрын 9 ширхэг нийтийн бие засах газруудыг 5 ширхэг усны машинаар цэвэр усаар хангасан.

- Нойлуудын байрлалын хувьд морь барианы хэсэгт 2 ширхэг, наадмын комисст 1 ширхэг, Цагдаа толгойд 1 ширхэг, үйлчилгээний А талбайд 4 ширхэг нийт 9 байрлалд 18 ширхэгийг байршуулан үйлчилсэн.
- Ус сувгийн удирдах газрын 2 худаг болон Монгол наадам цогцолборын 1 худагас нийт 360 тн цэвэр ус нийлүүлсэн.
- Морь явахад болон орж ирэхэд талбайд нийт 120 тн усалгаа хийсэн.



- Гэрээт байгууллагын усны машин нойлуудад цэвэр ус хийж буй нь

Талбайн хог цэвэрлэгээ, нойлуудын засвар үйлчилгээ, бусад туслах материалын зардал /2 өдрөөр/

Хүй долоон худагт 2019 оны 7 дугаар сарын 20, 21-ны өдрийг дуустал наадамчдад үйлчлэх нийтийн бие засах газруудын бохирыг соруулж тээвэрлэн асгах ажлын төсвийг 5,544,000 төгрөгөөр, талбайн хог цэвэрлэгээ, нойлуудын засвар үйлчилгээг хийж гүйцэтгэх төсвийг 1,697,602 төгрөгөөр тус тус баталсан. Батлагдсан төсвийн хүрээнд мэргэжлийн компаниудаас ирүүлсэн саналыг хүлээн авч “Суман хас” ХХК-тай 2019 оны 07 дугаар сарын 19-ны өдөр МНЦ 19/155 тоот гэрээ байгуулан ажилласан. Тус байгууллага нь Хүй долоон худаг дахь морь барианы газрын 9 ширхэг нийтийн бие засах газруудын бохир усыг 2 ширхэг бохирын машинаар 29 удаагийн рейсээр соруулан асгаж, 2 ширхэг хогны машинаар 10 удаагийн рэйсээр хог тээвэрлэн асгаж ажиллаа.

- Нойлуудын байрлалын хувьд морь барианы хэсэгт 2 ширхэг, наадмын комисст 1 ширхэг, Цагдаа толгойд 1 ширхэг, үйлчилгээний А талбайд 4 ширхэг нийт 9 байрлалд 18 ширхэгийг байршуулан үйлчилсэн.
- 329 тн бохир ус соруулан цэвэрлэх байгууламжийн бохирын цооногт асгасан.



Гэрээт байгууллагын бохирын машин нойлуудаас бохир ус соруулж буй нь

Эко автобус барих жолоочийн зардал /2 өдрөөр/

Цахилгаан машин ажиллуулах зардлын төсвийг 3,486,000 төгрөгөөр баталсан. Тус захиалгат ажлыг “Аргай энерги” ХХК-тай 2019 оны 07 дугаар сарын 19-ны өдөр МНЦ 19/156 тоот гэрээгээр байгуулсан. Тус компани нь нийт 27 ажилтантайгаар 07 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд 09:00- 19:00 цагийн хооронд наадамчин олонд үйлчлэн ажилласан. Захиалгат ажил гүйцэтгэх хугацаандаа “Аргай энерги” ХХК нь жолооч, ажилчдын бэлэн байдлыг 100% ханган, цэнэглэлт, техникийн жижиг засвар үйлчилгээг цаг тутамд хийж, үйлчилгээний стандартыг бүрэн мөрдөж, аюулгүй ажиллагаандаа өндөр анхаарал тавин гэмтэл, зөрчил гаргалгүйгээр хамтран ажиллаа.



Гэрээт байгууллагын жолооч нар эко автобусаар наадамчдад болон комиссын зохион байгуулагчдад үйлчилж буй нь

Тайзны хөгжим, лед дэлгэц, гэрэл ажиллуулах зардал /2 өдрөөр/

“Шигшмэл хурдан морьдын Их хурд-8”, Монгол туургатны морьтны өв соёлын наадмын морь барианы тайз босгох, тайзны аюулгүй ажиллагааг ханган ажиллах, тайз хөгжим, лед дэлгэц угсрах, буулгах ажлыг “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ хариуцан ажилласан. Иж бүрэн тайз хөгжим, лед дэлгэц угсрах, ажиллуулах зардалд 3,000,000 төгрөг төсөв хуваарилсан. Үүрэгт ажлын хүрээнд 4*6-ын хэмжээтэй тайз, 3*6-ын хэмжээтэй лед дэлгэц, шугаман зурвасын чанга яригч 6ш, намын чанга яригч 6ш, хяналтын чанга яригч 12, тоон фульт 1ш, лед дэлгэцийн удирдлагын төхөөрөмж 1ш-ыг тус тус гарган иж бүрэн хөгжим хэрэгсэл угсарч өдрийн турш ажиллуулсан. Наадмын хөгжмийн техникчээр хөгжмийн инженер Ц.Эрдэнэбаатараар ахлуулсан 3 хүний бүрэлдэхүүнтэй баг ажилласан.



Талбайд хөгжим, гэрэл, ледийн инженерүүд ажиллаж буй нь

“Шигшмэл хурдан морьдын Их хурд-8”, Монгол туургатны морьтны өв соёлын наадмын төлөвлөгөөт ажлууд бүрэн хийгдэж дууссан. Хүй долоон худгийн тохижилт, үйлчилгээний ажлууд “ММСУХ”-оос гаргасан Их хурд-8 наадмын талбайн зургийн дагуу цаг хугацаандаа хийгдэж нийт талбайн зохион байгуулалт эмх цэгцтэй байж, нийтийн бие засах газрын үйлчилгээ, цэвэрлэгээнд анхаарч, орчны тохижилтыг сайжруулан, хуурайшилтын үед талбайн усалгааг нэмэгдүүлэн, эко автобусаар өндөр бүрэлдэхүүнтэй үйлчлэн ажиллаа.

Наадмын бэлтгэл ажлын хугацаа хэдийгээр богино байсан ч “ММСУХ” ТББ-ын хүсэлт болон НЗДТГ-аас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу байгууллагын ажилчид 5 өдрийн турш илүү цагаар ажиллан талбайн зохион байгуулалт, тохижилт, үйлчилгээний бэлтгэл ажлыг тогтоосон хугацаанд амжилттай хийж гүйцэтгэлээ.

Засгийн газрын тогтоолтой тус наадмыг НЗДТГ хамтран зохион байгуулж буйтай холбогдуулан манай байгууллагын түрээсийн төлбөрийг олгох боломжгүй хэмээн шийдвэрлэсэн. “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ нь жил бүр Нийслэлийн төсөвт орлого төвлөрүүлэн ажиллах үүрэгтэй байдаг тул тодорхой хэмжээний түрээсийн төсөв авах хүсэлтэй байгаагаа Нийслэлийн удирдлагуудад удаа дараа илэрхийлсэн боловч төдийлөн шийдвэрт хүрэлгүйгээр тус наадмыг дан үйл ажиллагааны зардлаар зохион байгуулсан болно.

Байгууллагын удирдлага төлөвлөгөөний гүйцэтгэл, чанарын хэрэгжилтэд хяналт тавин, үйлчилгээ үзүүлэх байгууллагуудтай төлбөрийг гүйцэтгэлээр төлөх хэлбэрээр тохиролцон гэрээ байгуулан захиалгат ажлуудыг хийж гүйцэтгүүлэн үр дүнг хянан, тулгамдсан асуудлуудыг цаг тухай бүрд нь шийдвэрлэн, гэрээ дүгнэсэн акт үйлдэн ажилласан.

Наадмын өдрүүдээр хийж гүйцэтгэсэн ажлын тайланг “ММСУХ”-ны удирдлагууд болон “Их хурд-8” наадмын комиссын даргад хүргүүлэн танилцуулсан болно. Нар хур тэгширсэн дэлгэр сайхан өдрүүдэд зохион байгуулагдсан “Шигшмэл хурдан морьдын Их хурд-8”, Монгол туургатны морьтны өв соёлын наадам тохижилт, зохион байгуулалт, үйлчилгээний хувьд чанартай сайн байж наадамчин олон сэтгэл хангалуун байлаа. Мөн “ММСУХ” ТББ-ын удирдлагууд сэтгэл хангалуун байж байгууллагын хамт болон удирдлагад талархсан сэтгэгдлээ илэрхийлж байсан юм.

“Улаанбаатар төмөр зам”-ын 70 жилийн ойн баярыг Хүй долоон худагт тэмдэглэн өнгөрүүллээ.

“Улаанбаатар төмөр зам” Хувь нийлүүлсэн нийгэмлэгийн түүхт 70-н жилийн ойд зориулсан баяр наадам 2019 оны 08 дугаар сарын 2, 3-ны өдрүүдэд Хүй долоон худагт амжилттай зохион байгуулагдлаа. Тус баярын арга хэмжээнд “Монгол Наадам Цогцолбор” ОНӨТҮГ газрын дарга Д.Хатанбаатараар ахлуулсан ажлын хэсэг бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаа. Наадмын ерөнхий зохион байгуулагчаар байгууллагын орлогч дарга Р.Дашгомбо ажиллан 3 албаны нийт 33 ажилтан ажиллаж тохижилт, засвар, үйлчилгээ, зохион байгуулалтын ажлыг гаргасан төлөвлөгөөний дагуу хугацаанд нь хийж гүйцэтгэлээ.

“Улаанбаатар төмөр зам” Хувь нийлүүлсэн нийгэмлэгийн түүхт 70-н жилийн ойд зориулсан баяр наадмын зохион байгуулалтын бэлтгэл ажил 7 хоногийн хугацаанд хийгдэж “Улаанбаатар төмөр зам” болон дотооддоо 2 удаа хуралдан Маркетингийн хэлтсээс гаргасан 17 зүйл бүхий ажлын төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн ажлуудыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэн, гэрээт байгууллагуудаас гүйцэтгэлээ шаардан хяналт тавьж, тулгамдсан асуудлуудыг цаг тухайд нь шийдвэрлэж ажиллаа.




Талбайн харагдах байдал

Хийгдсэн ажлууд:

“Улаанбаатар төмөр зам” Хувь нийлүүлсэн нийгэмлэгийн түүхт 70 жилийн ойд зориулсан баяр наадмаар Хүй долоон худгийн нийтийн эзэмшлийн хуваарьт зам талбайд усалгаа, цэвэрлэгээ хийх, нийтийн бие засах газрыг цэвэр усаар хангах, үзэгчдийн сандал угсрах, экоавтобусаар үйлчлэх, майхан асар угсрах, радио узель ажиллуулах ажилд “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын 33 ажилтан, гэрээт байгууллагуудаас 37 ажилтан нийт 70 хүн, 16 экоавтобус, 11 автомашин, техник гарч ажилласан.

Тохижилтын ажлын хувьд:

- Морь барианы газар үзэгчдийн сандал 1300 ширхгийг угсарч байрлуулсан.
- Наадмын төв талбайд үндэсний бөх барилдахад зориулан үзэгчдийн сандал 1500 ширхгийг угсарч байрлуулсан.
- Наадамчдад болон зохион байгуулагчдад зориулан 16 ширхэг эко автобусаар бүтэн өдрийн турш үйлчилсэн.
- Талбайд нийт 9 байрлалд контейнерэн нойлыг ажиллуулан цэвэр усаар хангаж олон нийтэд үйлчилсэн.
- 6*4 болон 6*9 хэмжээтэй 4 ширхэг монгол майхан талбайд байршуулсан.
- Арга хэмжээ болж буй талбайд нийт 40 ширхэг зөөврийн хогийн сав байршуулсан.
- Мөн талбайд гудамжны сандал 30 ширхгийг байршуулсан.
- Зам дагуух 2м х 2,7м хэмжээтэй мэдээллийн 8 ширхэг самбарт наадмын сурталчилгааг өлгөн олон нийтэд хүргэсэн.



. “Улаанбаатар төмөр зам”-ын 70 жилийн ойн баярын талбайн схем зураг

Үйлчилгээний ажлын хувьд:

- Байгууллагын крантай машинаар морь барианы газар болон соёл урлагийн талбайгаас хуушуурын талбай хүртэл сандалны рамм зөөвөрлөх, агуулахаас монгол майхан болон хогийн сав, гудамжны сандал талбайн тохижилтод зориулан зөөвөрлөх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.
- Бобкат машинаар зам дагуух самбаруудад хулдаас тогтоох, үзэгчдийн сандалны тавцан зөөвөрлөх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.
- Усны машиныг бэлэн байдалд байлган бөхийн барилдаан болж буй талбайн дотор талд болон мөн гадна талаар тус бүр 1 удаа усалгаа хийж тоосжилтыг дарж ажиллаа.
- “Мөнхийн амьд ус” ХХК-тай нийтийн контейнерэн бие засах газруудыг цэвэр усаар хангах ажлын гэрээ байгуулан наадмын нойлын үйлчилгээний асуудлыг тасалдалгүйгээр хийж гүйцэтгэсэн.
- Талбайд 10 тонн-ын хогны машин ажиллаж хогийн савнууд дахь хогийг суллан хотруу 6 удаа тээвэрлэн асгасан.



Бусад хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хувьд:

- Хүй долоон худагт байрлалтай нийт 5 шон бүхий радио үзелийн холбогдох засварыг хийж 2 хоногийн турш хурдан морины уралдаан болон наадамчин олонд зориулсан зарлал, мэдээ, мэдээлэл, цаг агаарын мэдээг цаг тухай бүрд нь дамжуулж байсан.
- “Улаанбаатар төмөр зам”-ын 70 жилийн ойн баяр наадмын талбайн хог цэвэрлэгээг “Дэлгэр баян хайрхан” ХХК гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн.
- 2 насны морины уралдааны үеэр зурхайн цагаан зурвасыг тодруулан, төв индрийг зочдод зориулан цэвэрлэж, индэр дээр туг байршуулсан.

Санхүүгийн гүйцэтгэлийн хувьд:

2019 оны 08 дугаар сарын 02, 03-ны өдүүдэд “УБ төмөр зам” нийгэмлэгийн 70 жилийн ойн баяр наадмыг 29 840 000 төгрөгийн төсөвтэйгээр 2019 оны 07 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан МНЦ 19/44 дугаартай гэрээт ажлын дагуу амжилттай зохион байгуулагдлаа. Нийт 29 840 000 төгрөгийн төсвөөс 16 820 000 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэн 13 020 000 төгрөгийг бусдаар гүйцэтгүүлэх үйл ажиллагаанд зарцуулсан. Үүнээс 9 ширхэг контнейрэн нийтийн бие засах газрыг цэвэр усаар хангах ажлыг 1 411 000 төгрөгийн төсөвт “Мөнхийн амьд ус” ХХК-аар гүйцэтгүүлж, 16 ширхэг экобус барих ажлыг 3 944 000 төгрөгийн төсөвт “Элэг нэгтэн” ХХК-аар, нойлуудын үйлчилгээ, талбайн хог цэвэрлэгээний 5 665 000 төгрөгийн төсөвтэй ажлыг “Дэлгэр баян хайрхан” ХХК-тай, Эко автобус чимэглэл, индрийн

тохижилт хийх 2 000 000 төгрөгийн төсөвт ажлыг “ Би Эл Ти Ди” ХХК-тай тус тус гэрээ байгуулан гүйцэтгүүлж хяналт тавин ажиллаа.

Монгол улсад авто замын салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойн баяр наадмыг “хүй долоон худагт зохион байгууллаа.

Монгол улсад авто замын салбар үүсч хөгжсөний 90-н жилийн ойд зориулсан баяр наадам 2019 оны 08 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд Хүй долоон худагт амжилттай зохион байгуулагдлаа.Тус баярын арга хэмжээнд “Монгол Наадам Цогцолбор” ОНӨТҮГ-ын дарга Д.Хатанбаатараар ахлуулсан ажлын хэсэг бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаа. Наадмын ерөнхий зохион байгуулагчаар ахлах мэргэжилтэн Б.Солонго ажиллан 3 албаны нийт 33 ажилтан ажиллаж тохижилт, засвар, үйлчилгээ, зохион байгуулалтын ажлыг гаргасан төлөвлөгөөний дагуу хугацаанд нь хийж гүйцэтгэлээ.

Наадмын зохион байгуулалтын бэлтгэл ажил 4 хоногийн хугацаанд хийгдэж ажлын төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн ажлуудыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэн, гэрээт байгууллагуудаас гүйцэтгэлээ шаардан хяналт тавьж, тулгамдсан асуудлуудыг цаг тухайд нь шийдвэрлэж ажиллаа.

Хүй долоон худагт болсон уг наадмын үеэр гурван насны /их нас, шүдлэн, соёолон/ нийт 207 хурдан морины уралдаан, сурын харваа, үндэсний 128 бөхийн барилдаан, “Алтан шар замаа дуулъя” баярын цэнгүүн, баяр наадмын нээлт, хаалтын үйл ажиллагаа болж 7.000 орчим иргэд үзэж сонирхсон юм.



Талбайн харагдах байдал

Хийгдсэн ажлууд:

Монгол улсад авто замын салбар үүсч хөгжсөний 90-н жилийн ойд зориулсан баяр наадмаар Хүй долоон худгийн нийтийн эзэмшлийн хуваарьт зам талбайд усалгаа,

цэвэрлэгээ хийх, нийтийн бие засах газрыг цэвэр усаар хангах, бохир ус соруулах, үзэгчдийн сандал угсрах, экоавтобусаар үйлчлэх, майхан асар угсрах, радио узель ажиллуулах ажилд “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын 34 ажилтан, гэрээт байгууллагуудаас 22 ажилтан нийт 56 хүн, 10 экоавтобус, 8 автомашин, техник гарч ажилласан.

Тохижилтын ажлын хувьд:

- Морь барианы газар үзэгчдийн сандал 500 ширхгийг угсарч байрлуулсан.
- Наадмын төв талбайд үндэсний бөх барилдахад зориулан үзэгчдийн сандал 550 ширхэгийг угсарч байрлуулсан.
- Наадамчдад болон зохион байгуулагчдад зориулан 10 ширхэг эко автобусаар 2 өдрийн турш үйлчилсэн.
- Талбайд нийт 6 байрлалд контейнерэн нойлыг ажиллуулан цэвэр усаар хангаж, бохир ус соруулан олон нийтэд үйлчилсэн.
- 6м х 4м хэмжээтэй 3 ширхэг монгол асар талбайд байршуулсан.
- Арга хэмжээ болж буй талбайд нийт 30 ширхэг зөөврийн хогийн сав байршуулсан.
- Зам дагуух 2м х 2,7м хэмжээтэй мэдээллийн 9 ширхэг самбарт наадмын сурталчилгааг өлгөн олон нийтэд хүргэсэн.
- Наадмын өдрүүдэд талбайн хог цэвэрлэгээг тухай бүрд нь хийж, хогны машинд ачин зөөж ажилласан.



“Улаанбаатар төмөр зам”-ын 70 жилийн ойн баярын талбайн схем зураг

Үйлчилгээний ажлын хувьд:

- Байгууллагын крантай машинаар морь барианы газар болон соёл урлагийн талбайгаас хуушуурын талбай хүртэл сандалны рамм зөөвөрлөх, агуулахаас монгол майхан болон хогийн савыг талбайн тохижилтод зориулан зөөвөрлөх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Бобкат машинаар зам дагуух самбаруудад хулдаас тогтоох, үзэгчдийн сандлын тавцан зөөвөрлөх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.
- Усны машиныг бэлэн байдалд байлган бөхийн барилдаан болж буй талбайн дотор талд болон мөн гадна талаар тус бүр 1 удаа усалгаа хийж тоосжилтыг дарсан.
- “Суман хас” ХХК-тай нийтийн контейнерэн бие засах газруудыг цэвэр усаар хангах, бохир ус соруулах ажлын гэрээ байгуулан наадмын нойлын үйлчилгээний асуудлыг тасалдалгүйгээр хийж гүйцэтгэсэн.
- Талбайд 10 тонн-ын хогны машин ажиллаж хогийн савнууд дахь хогийг суллан хотруу 4 удаа тээвэрлэн асгасан.



. Төв талбайд үзэгчдийн сандал угсрагдсан байдал

Морь барианы газар үзэгчдийн сандал байршуулсан байдал

Бусад хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хувьд:

- Монгол улсад авто замын салбар үүсч хөгжсөний 90-н жилийн ойд зориулсан баяр наадмын талбайн хог цэвэрлэгээг “Элэг нэгтэн” ХХК гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн.
- 3 насны морины уралдааны үеэр зурхайн цагаан зурвасыг тодруулан, төв индрийг зочдод зориулан цэвэрлэж, индэр дээр туг байршуулсан.

Санхүүгийн гүйцэтгэлийн хувьд:

2019 оны 08 дугаар сарын 10, 11-ны өдүүдэд “Монгол улсад авто замын салбар үүсч хөгжсөний 90-н жилийн ойд зориулсан баяр наадмыг 29 593 000 төгрөгийн төсөвтэйгээр 2019 оны 08 дугаар сарын 10-ны өдөр “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГазартай байгуулсан МНЦ 19/162 дугаартай гэрээт ажлын дагуу амжилттай зохион байгуулагдлаа. Нийт 29 593 000 төгрөгийн төсвөөс 11 680 000 төгрөгийг Орон нутгийн төсөвт төвлөрүүлэн 17 913 000 төгрөгийг бусдаар гүйцэтгүүлэх үйл ажиллагаанд зарцуулсан. Үүнээс 6 ширхэг контнейрэн нийтийн бие засах газрыг цэвэр усаар хангах, бохир ус соруулах, талбайн усалгаа, нийтийн бие засах газрын цэвэрлэгээ хийх ажлыг 6 318 000 төгрөгийн төсөвт “Суман хас” ХХК-аар гүйцэтгүүлж, 10 ширхэг экобус барих, талбайн хог цэвэрлэгээний ажлыг 7 820 000 төгрөгийн төсөвт “Элэг нэгтэн” ХХК-тай тус тус гэрээ байгуулан гүйцэтгүүлж хяналт тавин ажиллаа.

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-тай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээнд тусгагдсан төлөвлөгөөт ажлууд бүрэн хийгдэж дууссан.

Монгол улсад авто замын салбар үүсч хөгжсөний 90-н жилийн ойд зориулсан баяр наадам Хүй долоон худагт 2019 оны 08 дугаар сарын 10, 11-ны өдөр амжилттай зохион байгуулагдаж дууссан. Талбайн тохижилт, үйлчилгээний ажлууд төлөвлөгөөний дагуу цаг хугацаандаа хийгдэж нийт талбайн зохион байгуулалт эмх цэгцтэй байж, нийтийн бие засах газрын үйлчилгээ, цэвэрлэгээнд анхаарч, орчны тохижилтыг сайжруулан, эко автобусаар наадамчдад үйлчлэн ажиллаа.

“Байгууллагын аварга” шалгаруулах спортын арга хэмжээ зохион байгуулагдлаа

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Улаанбаатар марафонд нэгдэцгээе” цомын аяны хүрээнд “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын ажилтан алба хаагчдын дунд “Байгууллагын аварга” шалгаруулах спортын таван төрөлт тэмцээн 2019 оны 03 дугаар сарын 28,29-ны өдрүүдэд зохион байгууллаа.

“Байгууллагын аварга” шалгаруулах уг спортын арга хэмжээнд нийт ажилтан, албан хаагчдыг сугалаагаар 4 багт хувааж 7-оос 8 тамирчинтайгаар ширээний теннис, дартс, шатар, гар бөмбөг, сагсан бөмбөг зэрэг спортын таван төрлөөр хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн юм.



/Спорт өдөрлөгт оролцсон ажилчид/

Нийт багийн дүнгээр:

Нэгдүгээр байранд Д.Хатанбаатар ахлагчтай баг, тамирчид орсон бол Хоёрдугаар байранд Р.Дашгомбо ахлагчтай баг, Гуравдугаар байранд З.Очирбат ахлагчтай баг нар тус тус орлоо.

“Хөгжлийн лиг 2019” тэмцээний тохижилт үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэлээ

“Монголын Залуу Волейболчдын Холбоо” ТББ үүсгэн байгуулагдсаны 5 жилийн ой тохиож буйтай холбогдуулан тус холбооноос “Хөгжлийн лиг-2019” тэмцээнийг зохион байгууллаа. Тус тэмцээн нь 2 дугаар сараас эхлэн 4 дүгээр сарыг дуустал зохион байгуулагдаж өнгөрөгч амралтын өдрүүдэд шигшээ тоглолтууд нь явагдсан. Уг арга хэмжээнд “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ нь хамтран ажиллаж шигшээ тоглолтод 300 үзэгчдийн сандал угсран байрлуулж үзэгчдийн тав тухыг ханган ажиллаа.



“МНЦ” Гэр баазын зоогийн газрыг гэрчилгээжүүлээ

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ нь Хүй долоон худагт байрлах гэр баазад амарч буй иргэд, байгууллагуудад халуун хоол цайгаар үйлчлэх зорилготой зоогийн газрыг ажиллуулж эхэлсэн.

Тус зоогийн газрыг ажиллуулахад худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх эрх бүхий гэрчилгээ авах шаардлагатай байдаг бөгөөд тус зоогийн газрын гэрчилгээг авахад шаардлагатай бүрдүүлэх материалыг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын дэргэдэх “Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөл”, “Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын” тэргүүлэгчдийн 2014 оны 07 дугаар тогтоол, Дүүргийн засаг даргын 2016 оны А/340 дүгээр захирамжийн дагуу тус тус бүрдүүлэн Сонгинохайрхан дүүргийн “Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс”-тэй дүүргийн нутаг дэвсгэрт Үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулах нэг жилийн хугацаатай /2019.03.13-2020.03.13 хүртэл/ гэрээ байгуулан авлаа.



Мөн Хүй долоон худагт тогтвор суурьшилтай ажлын байр бий болгох үүднээс ТҮА ажилтан Ч.Чонцолдуламыг "Чухал амжилт" сургалтын төвд тогоочийн 1 сарын сургалтад хамруулан 4 зэргийн тогоочийн мэргэжлийн үнэмлэхтэй болгосон.

ТАНИЛЦСАН:

ДАРГА

Д.ХАТАНБААТАР

ХЯНАСАН:

ОРЛОГЧ ДАРГА

З.ОЧИРБАТ

ТАЙЛАН НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН

Ц.ЦОГТГЭРЭЛ

Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ын
2019 оны жилийн эцсийн тайлангийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ
/2019 оны жилийн эцсийн байдлаар/
“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ

НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ-ӨРХ БҮРТ

2019 оны 12 дугаар сарын 04-ны өдөр
Улаанбаатар хот

Д/д	Заалт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хэрэгжилтийн хувь
1.4	Аялал жуулчлалын төв болно	Хүй долоон худагт дахь "Монгол наадам цогцолбор"-т үндэсний спортыг хөгжүүлэх, төрөлжсөн аялал жуулчлал, бизнес, соёлын төв /морин уралдаан, морин аялал, бизнес үзэсгэлэнгийн төв/ барьж байгуулахад дэмжлэг үзүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын хөрөнгө оруулалтыг татна.	"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ	70%
1	1.4.2	Биелэлт: Хүй долоон худаг Монгол наадам цогцолборт жил бүрийн Үндэсний Их баяр наадам зохион байгуулагдаж байна. Мөн жуулчдыг татах хүрээнд Тал нутгийн чимээ этник шоун тоглолт, Бэсрэг наадам, Монгол хүү хүүхдийн баяр, Эрүүл иргэн эко хөгжил сдорт өдөрлөг, Айрагны баяр зэрэг арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна. Үр дүн, үр нөлөө: Хүй долоон худагт хөрөнгө оруулалтын ажил хийснээр дэд бүтэц сайжирч наадам, спорт өдөрлөг тогтмол зохион байгуулагдах боломжтой. Мөн дээрх Бэсрэг наадам, Тал нутгийн чимээ этник шоун тоглолт зохион байгуулагдсанаар Хүй долоон худагт жуулчны урсгал нэмэгдэх Монгол дахь жуулчны тоо нэмэгдэх боломжтой. Мөн Монголын өв соёл, эрийн гурван наадам, язгуур урлаг бий бийлсээг дэлхий дахинд сурталчилах боломжтой.		

ХЯНАСАН:
"МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР" ОНӨТҮГ-ЫН ДАРГА
Д.ХАТАНБААТАР
БОЛОВСРУУЛСАН:
"МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР" ОНӨТҮГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН
Ц.ЦОГТГЭРЭЛ

**"МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР" ОНӨТҮГ-ЫН НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД
ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУСГАГДСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ**

/2019 оны жилийн эцсийн байдлаар/

2019 оны 12 дугаар сар 24

Улаанбаатар хот

№	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2019 онд хүрэх түвшин үр дүн	Шаардлагатай хөрөнгийн хэмжээ хөрөнгийн эх үүсвэр	Хариуцах байгууллага	Хэрэгжилтийн явц
1-45	1.4.2 Хүй долоон худагт дахь "Монгол наадам цогцолбор"-т үндэсний спортыг хөгжүүлэх, төрөлжсөн аялал жуулчлал, бизнес, соёлын төв /морин уралдаан, морин аялал, бизнес үзэсгэлэнгийн төв/ барьж байгуулахад дэмжлэг үзүүлж, төр, хувийн хэвшлийн туншлэл, гадаадын хөрөнгө оруулалтыг татна.	Бэсрэг наадам зохион байгуулна.	Хамрагдах жуулчдын тоо	200	Зүүн хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн төв болгох зардал	Монгол наадам цогцолбор,	100%
		Үр дүн үр нөлөө: Тал нутгийн чимээ этник, шоун тоглолтыг 2019 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр Хүй долоон худагт зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд Нийт 186 жуулчин хамрагдсан бөгөөд Улаанбаатар чуулга, Домог, Жонон хамтлагууд ая дуугаа өргөж Монголд ирсэн жуулчдад үндэсний өв соёл, язгуур урлагыг таниулан сурталчилсан.					
		Тал нутгийн чимээ этник шоу	Хамрагдах жуулчдын тоо	200	Байгууллагын хөтөлбөр арга хэмжээний зардал	Монгол наадам цогцолбор, НСУГ, НАЖТ	
		Үр дүн үр нөлөө: Бэсрэг наадам үзүүлэх тоглолтыг 2019 оны 08 дугаар сарын 29-нд зохион байгуулахаар товлж, журмын дагуу захирамжийн төсөлд холбогдох албан тушаалтнуудаас санал авсан боловч хотын даргын өгсөн үүрэг чиглэлийн дагуу цуцлагдсан.					
1-46		Морин спортын төв байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт	100	Зүүн хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн төв болгох зардал	Монгол наадам цогцолбор	Төсвийн байдлаас шалтгаалан 2020 оны хөрөнгө оруулалтад тусгахыг НЗДТГ-с үүрэг болгосон.

ХЯНАСАН:

"МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР" ОНӨТҮГ-ЫН ДАРГА

Д.ХАТАНБААТАР

БОЛОВСРУУЛСАН:


"МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР" ОНӨТҮГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Ц.ЦОГТГЭРЭЛ

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН 2019 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН

	Нийт	УИХ-ын тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Засгийн газрын тогтоол	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	НИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоол	Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	5			5			
Хяналтад авсан нийт зүйл заалтын тоо	8			8			
Бүрэн хэрэгжсэн 100%				3			
Хэрэгжих шатанд 70%				2			
Хэрэгжилт хангалтгүй 30%							
Хэрэгжээгүй							
Хэрэгжилтийг тооцох, хугацаа болоогүй							
Биелэлтийн дундаж				88%			



ХЯНАСАН: ДАРГА

Д.ХАТАНБААТАР

БОЛОВСРУУЛСАН: ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Ц.ЦОГТГЭРЭЛ

**"МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР" ОНӨТҮГ НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС ЯВУУЛСАН 2018 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГАЛТЫН МӨРӨӨР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ АЖИЛ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТ**

2019 оны 12 дугаар сарын 24

Улаанбаатар хот

Д/д	Үүрэг даалгавар	Хариуцах эзэн	Хугацаа	Биелэлт
1	Хариуцлагын жилийн хүрээнд гарсан тогтоол, тушаалын биелэлтийг хангаж ажиллах	Хяналт- үнэлгээ шинжилгээ хариуцсан мэргэжилтэн	Байнга	Монгол улсын засгийн газрын 2018 оныг хариуцлагын жил болгон зарлах тухай 32 дугаар тогтоол, 2017 оны засгийн газрын 01 тоот албан даалгавар, 2018 оны 258 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг хангах үүднээс газрын даргын 2018 оны "Сахилга хариуцлага дэг журмыг чангатгах" А/48 тоот тушаал гарган мөрдөн ажиллаж байна. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралтын дагуу тогтоол шийдвэрийн биелэлтийг улирал тутам гаргаж НЗДТГ-т хүргүүлэн ажиллаж байна.
2	Нийслэлийн эдийн засаг нийгмийн 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан төсөл арга хэмжээг чанартай үр ашигтай зохион байгуулах	Ахлах мэргэжилтэн	2,3 –р улиралд	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016- 2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.2-т заасан "Монгол наадам цогцолбор"-т үндэсний спортыг хөгжүүлэх, төрөлжсөн аялал жуулчлал, бизнес, соёлын төв болгох" заалтын хүрээнд Тал нутгийн чимээ этник шоу, Бэсрэг наадам зохион байгуулж Морин спортын төв байгуулахаар төлөвлөсний дагуу "Тал нутгийн чимээ-2019" үндэсний урлагийн тоглолтыг 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр Хүй долоон худат амжилттай зохион байгуулсан. "Монгол наадам" үндэсний соёл, урлаг, спортын цогцолборын ирээдүйн төлөвлөлт, бүтээн байгуулалт, хэтийн зорилгыг олон нийтэд танилцуулах мөн Хүй долоон худгийн сэрүүн сайхан талд нар жаргах үеэр Монгол үндэсний язгуур урлагийн шилдэг тоглолтуудыг Монгол улсад ажиллаж, амьдарч байгаа болон мөн

				аялалын журмаар ирсэн гадаадын иргэд, жуулчдад үзүүлж сонирхуулах, түүгээр дамжуулан Хүй долоон худгийн ерөнхий төлөвлөгөөг танилцуулсан. Энэ арга хэмжээнд Хорват, Турк, Хятад, Герман, Япон, Солонгос зэрэг 6 орны 186 жуулчин ирж үзэж сонирхсон юм. Морин спорт сургалтын төв байгуулахад шаардагдах санхүүжилтын дэмжлэг хүссэн албан бичгийг 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Нийслэлийн Засаг даргын тамгын газрын дарга М.Отгонбаярт хүргүүлсэн. Тус албан бичгийн хариуг 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдөр НЗДТГ-ын Төсвийн ерөнхий мэргэжилтэн Б.Төгсхам 2020 оны хөрөнгө оруулалтын төсвийн тусгуулах хариу өгсөн. Мөн жуулчдад зориулсан бэсрэг наадмыг 2020 онд хийх чиглэлийг Нийслэлийн Засаг даргаас үүрэг болгосон. Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүмртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм журмыг баримтлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. 2019 онд цалин хөлс болон гэрэл цахилгааний төлбөр болох нийт 23 сая төгрөгийг хэмнэж ажилласан.
3	Төсвийн сахилга бат хариуцлагыг чанд сахиж, тэвчиж болох зардлыг хэмнэх	Нягтлан бодогч	Байнга	
4	Байгууллагын үйл ажиллагааны залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, ажилчин албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулан, нийгмийн баталгааг бэхжүүлэх чиглэлээр тодорхой үр дүнтэй ажил зохион байгуулах	Хууль, хүний нөөцийн мэргэжилтэн	Байнга	

5	Байгууллагын мэдээлэл, шийдвэр хэрэгжүүлж байгаа арга хэмжээг ил тод нээлттэй болгох	Хууль, хүний нөөцийн мэргэжилтэн	Байнга	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль", Засгийн газрын 2019 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан "Мэдээллийн ил тод байдлыг хангах журам", Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан "Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт" зэрэг хууль журмыг ханган ажиллаж байна.
6	Албан хаагчдын цаг ашиглалт ажлын бүтээмжийг сайжруулах	Хууль, хүний нөөцийн мэргэжилтэн	Байнга	Нийт албан хаагчдын цаг ашиглалт ажлын бүтээмж 2019 оны эцсийн байдлаар 95% тай ажиллаж байна. UB, ERP программын тусламжтайгаар албан хаагчдын цаг ашиглалт нээлттэй ил тод болсон.
7	Иргэдийн оролцоотой- Хөгжлийн жилийн хүрээнд жилийн хүрээнд төлөвлөсөн ажлуудыг үр дүнтэй зохион байгуулах	Бүх алба	Байнга	Иргэдийн оролцоотой- Хөгжлийн жилийн хүрээнд "Монгол наадам цогцолбор" төслийн ерөнхий төлөвлөгөө, хэтийн зорилго, алсын харааг тодорхойлох зорилгоор байгууллагын дэргэдэх Орон тооны бус бодлогын зөвлөлийн гишүүд болон үндэсний спорт холбоодыг оролцуулсан Монгол наадам цогцолборын өнөөгийн байдал ирээдүйн чиг хандлага хэлэлцүүлгийг 2019 оны 12 сарын 24-нд зохион байгуулсан. ҮИБН болон Хүй долоон худаг дахь хурдан морины уралдааны зохион байгуулалт, тохижилтыг сайжруулах зорилгоор наадмын өдрүүдэд 1000 иргэнээс сэтгэл ханамжын судалгаа авч судалгааны дүгнэлтийг холбогдох газруудад хүргүүлэн ажиллаж байна.
8	Ирсэн бичгийн "Бүртгэл хяналтын карт" "Хариутай бичгийн шийдвэрлэлтийн мэдээ" "Зөрчлийн дэлгэрэнгүй мэдээ", шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж шаардлагатай арга хэмжээг авч ажиллах, жилийн эцсийн байдлаар хэвлэж архивлах	Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн	байнга	Хариутай бичгийн шийдвэрлэлтийн мэдээ, зөрчлийн дэлгэрэнгүй мэдээ болон ирсэн бичгийн бүртгэл хяналтын картыг 14 хоног 1 удаа буюу сард 2 удаа гаргаж байгууллагын даргаар хянуулдаг ба ирсэн баримт бичгийн бүртгэлийн дэвтэр хөтөлдөг. Албан бичиг хааж буй ажилтан, албан хаагчдын шийдвэрлэлтийг хянаж ажилладаг. 2019 оны 1 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 25-ны хооронд байгууллагад ирсэн бичиг болон байгууллагаас гадагш явсан бичгийг архивд бүрдүүлэн авсан. Үр дүн: 14 хоног тутам хариутай бичгийн шийдвэрлэлт,

				зөрчлийн дэлгэрэнгүй мэдээ, ирсэн албан бичиг, байгууллагаас явсан албан бичгийн мэдээ, тайланг гаргаснаар албан хаагчид албан бичгийг шийдвэрлэлтийг тухай бүр шийдвэрлэсээр зөрчил дутагдалгүй ажиллаж байна.
9	Албан хаагчид боловсруулж хэрэг бүрдүүлсэн баримтаа хадгалах хугацаа, агуулга, нэр төрлөөр нь зөв хэрэг бүрдүүлж хадгаламжийн нэгж болгох	Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн	Байнга	Нийслэлийн архивын газрын дэргэдэх ББНШАЗК-ын 2018 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 05 дугаар хурлын шийдвэрээр "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу ангилан бүртгэлд авсан. Үр дүн нь 2015 онд батлагдсан Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг 2018 онд шинэчлэн батлуулснаар 2019 онд архивт хүлээн авах баримтууд тодорхой болсон.
10	Баримтын данс, бүртгэлийг "Байгууллагын архивын ажлын үндсэн заавар"-ын 7.2 дахь хэсэгт заасны дагуу нэр төрөл тус бүрээр нь үйлдэх, баталгаажуулах	Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн	Байнга	Байгууллагын архивын ажлын үндсэн зааврын 7.2-ын дагуу баримтыг бүрдүүлэн ажиллаж байна. Үр дүн: Байгууллагын архивын ажлын үндсэн зааврын 7.2-ын дагуу баримтыг бүрдүүлэн авсан
11	Албан тушаалтан, зохион байгуулалтын нэгж бүрээс цаасан суурьт болон кино, дүрс бичлэг, гэрэл зураг, дуу авиа, зураг төсөл боловсон хүчний баримтыг архивд бүрэн бүрдлээр хүлээн авах	Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн	Байнга	Байгууллагын алба тус бүрээс хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримтын бүрдлийг хийсэн. Үр дүн: байгууллагын архивд тусгай төрлийн баримт бичигт бүрдүүлсэн.
12	"Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичиг" MNS 5140:2011 стандартыг албан тушаалтан бүр мөрдөж ажиллах	Бүх мэргэжилтнүүд	Байнга	Байгууллагын ажилтан албан хаагчид албан бичгийн төсөл төлөвлөгөө, тайланг зохион байгуулалт, захирамжлалын баримт бичиг MNS 5140:2011 стандартыг баримтлан ажиллаж байна. Үр дүн: MNS 5140:2011 стандартыг мөрдөж ажилласнаар байгууллагын ажилтан албан хаагчид албан бичгийн төсөл, тайлан, төлөвлөгөөгөө стандартын дагуу хийж хэвшсэн.
13	2017, 2018 оны даргын тушаалыг цахимжуулж архивын программд оруулах	Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн	Байнга	2019 оны 05 дугаар сарын 24-нөөс 06 дугаар сарын 07-ын хүртэл өнгөрсөн онууд болох 2017, 2018 онуудын байгууллагын даргын хүний нөөцийн

				асуудлаар гаргасан /arch.ulaanbaatar.mn/ цахимжуулсан архив үүсгэсэн.	тушаалуудыг цахимд	тус тус байршуулж
--	--	--	--	---	-----------------------	----------------------

ХЯНАСАН:

"МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР" ОНӨТҮГ-ЫН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:

"МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР" ОНӨТҮГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Д.ХАТАНБААТАР

Ц.ЦОПТГЭРЭЛ




“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ-ЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Шийдвэрийн дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ, (хүчинг үй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6
Засгийн газрын тогтоол					
258	1.7	Төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох	Ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэсэн буюу ажилдаа согтуу ирсэн тохиолдол гараагүй бөгөөд ийм тохиолдолд хөдөлмөрийн дотоод журмын 10.3.2 дахь заалтын дагуу сахилгын шийтгэл оногдуулах заалтыг оруулан ажиллаж байна. Газрын даргын тушаалаар 4 ажилтанд сануулах арга хэмжээ авч цалингийн хувийг хасан ажиллаж байна.		
258	1.10	Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах	Хөдөлмөрийн дотоод журамд ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар заалтыг хөдөлмөрийн дотоод журмын 3.19 дахь заалтад тусган ажиллаж байна.		
258	3	Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын бүх гишүүд, бүх шатны Засаг дарга Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн	Ажлын цаг ашиглалт бүтээмжийг нэмэгдүүлэх үүднээс ERP.ULANBAATAR.MN системээр бүртгэн ажиллаж байна. Мөн байгууллагын дотоод хяналтын төлөвлөгөөнд оруулан ажиллаж байна.		

		өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагын дарга нарт даалгасугай.			
23	3	Хавсралтаар төлөвлөгөөг оруулав. "Иргэн төвтэй үйлчилгээний жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг эрхлэх ажлын хүрээнд харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж ажлын тайланг улирал тутам Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүд аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. Жич Хавсралтаар оруулсан "ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ"-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-ний дагуу өөрийн нэр заасан ажлыг хүснэгтээр гаргаж тайлагнана.		Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн "Иргэн төвтэй үйлчилгээний жил болгон зарлах тухай" 23 дугаар тогтоолын төлөвлөгөөний хавсралтад "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын хариуцах ажил байхгүй бөгөөд Нийслэлээс 2019 оныг "Иргэдийн оролцоотой хөгжлийн жил" болгон зарласан бөгөөд энэ хүрээнд 2 ажил төлөвлөн хийж гүйцэтгэж байна. Зорилтот жилийн хүрээнд ҮИБН-ийн үеэр үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгаа авч холбогдох газруудад хүргүүлсэн. Мөн "Монгол наадам цогцолбор"-ын өнөөгийн байдал ирээдүйн чиг хандлага сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.	
33	2	Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай.		Энэ тогтоолын дагуу газрын даргын 2019 оны А/14 тоот тушаалаар ёс зүйн зөвлөлийг байгуулж, түүний ажиллах журмын боловсруулсан. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг дагаж мөрдөх үүргийг оруулан ажиллаж байна.	
59	3	Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан төлөвлөгөөнд туссан ажлын хүрээнд нарийвчилсан төлөвлөгөө гаргаж эрхэлсэн салбар, харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжилтийг зохион байгуулж тайланг хагас болон жилийн эцсийн байдлаар Аж үйлдвэржилтийн бодлогын зөвлөлд хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай.		"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-т 2019 онд худалдан авалт төлөвлөгөөгүй байна.	

59	4	"Эх оронч худалдан авалтийн жил"-ийн хүрээнд дотоодод үйлдвэрлэсэн үндэсний бараа бүтээгдэхүүнийг худалдан авч хэрэглэхийг нийт аж ахуйн нэгж байгууллага иргэдэд уриалсугай.	"Эх оронч худалдан авалтын жил" болгон зарлах тухай 59 дүгээр тогтоолын дагуу байгууллагын хэрэгцээт бараа материалыг дотоодод үйлдвэрлэсэн аж ахуй нэгжийн бараа бүтээгдэхүүнийг сонгон авч байна. Үүний хүрээнд ажилчдын хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлыг хангах үүднээс ариза интернэйшнэл ХХК-д үйлдвэрлэсэн ажлын хувцасыг 1.450.000 төгрөгөөр худалдан авч ажиллаж байна.	
456	1	Үндэсний их баяр наадмын "Монгол наадам цогцолбор"-т зориулан нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт хамаарах 551 га, Төв аймгийн Аргалант сумын нутаг дэвсгэрт хамаарах 12031 га, нийт 12582 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, хилийн цэсийг хавсралт ёсоор баталсугай.	МУ-ын 3Г-ын 2015 оны 11-р сарын 23-ны өдрийн 456-р тогтоолоор "Монгол наадам цогцолбор"-ын хэрэгцээнд зориулан нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт хамаарах 551га, Төв аймгийн Аргалант сумын нутаг дэвсгэрт хамаарах 12,031га буюу нийт 12,582 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах шийдвэр гарч, хилийн цэсийг тогтоож өгсөн хэдий ч 3Г-ын тогтоолоос өмнө болон хойно газар олголт хийгдсэнээс газрын давхцлын асуудал үүсэж, тус газар нь дүрмээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдал үүссэн. Улмаар нийслэлийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/890 дугаар захирамжаар "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-т олгогдсон улсын тусгай хэрэгцээний газрын давхцалын асуудлыг шийдвэрлэх талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөрөөр ахлуулсан ажлын хэсэг байгуулагдаж ажиллаж 2019 онд тусгай хэрэгцээний газрын	

			хэмжээ хилийн заагт өөрчлөлт орсны улмаас Төв аймгийн Аргалант сумын нутаг дэвсгэрт хамаарах 12,031 га газраас 2006 га газрыг улсын тусгай хэрэгцээний газраас чөлөөлж, шинээр 449 га газрыг нэмэх байдлаар нийт 10,474 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 5 дугаар тогтоолоор батлуулж Нийслэлийн СХД-ийн нутаг дэвсгэрт хамаарах газрын асуудлыг НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр НИТХ-аар оруулах төсөл өргөн барьж хэлэлцүүлж Барилга хот байгуулалтын яаманд.	
--	--	--	--	--



ХЯНАСАН: ДАРГА

Д.ХАТАНБААТАР

БОЛОВСРУУЛСАН: ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Ц.ЦОГТГЭРЭЛ

			хүчний үзүүлэлт	боловсон хүчин ажиллаж байна.		
		Хэсгийн дундаж:				
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	3	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо	Нийт-8 албан хаагчид шагналд хамрагдсан.		
			Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах	Гүйцэтгэлээр	Орон нутгийн төсвийн зардлаас санхүүжнэ 2019 оны 11 дүгээр сарын байдлаар нийт-44.175.0 мян.төг байна.	
	4	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	Сэтгэл ханаамж 80 хувиас дээш	Орон нутгийн төсвийн зардлаас санхүүжнэ	Албан хаагчдын ажиллах орчин, нөхцөл сайжирна.
			Албан хаагчдад сар бүр олгох	Гүйцэтгэлээр	Орон нутгийн төсвийн зардлаас санхүүжнэ	

			хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх	!		2019 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 37,000.0 мян.төг байна.	
5	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	Жилд 1-ээс доошгүй удаа	2019 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулсан.			
		Албан хаагчдын хамрагдалт	100 хувь	Нийт албан хаагчид зуун хувийн ирцтэй хамрагдсан.			
Хэсгийн дундаж:							
Үнэлгээний дундаж хувь:							

ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
		Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал	
1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Байгууллагын эрхэм зорилгыг тодорхойлон mnts.ub.gov.mn цахим хуудас, мэдээллийн самбар, пэйж хуудас зэрэгт байрлуулан ажиллаж байна. Цахим хуудсанд мэдээ мэдээлэл оруулах төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулж төлөвлөгөөний дагуу 57 мэдээ мэдээлэл, 13 тайлан мэдээ, бусад мэдээллийг холбогдох мэргэжилтнүүдээс авч цахим хуудсанд тухай бүр байршуулсан. - Газрын даргын тушаал - Хүний нөөц - Төсөв санхүү - Тайлан, төлөвлөгөө - Төсөл хөтөлбөр - Худалдан авалт - Өргөдөл гомдлын шийдвэрлэлт - Хууль, эрх зүй - Шилэн данс - Төрийн үйлчилгээ гэх мэт цэсийг мэдээлэлээр тогтмол баяжуулж цахим хуудасны хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Мөн байгууллагаас хүй долоон худагт зохион байгуулж байгаа баяр наадмын мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудас, facebook/Mongol наадам цогцолбор/, mnts.ub.gov.mn хуудсаар тус тус дамжуулан хүргэж байна.	

2	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Шаардлагатай ажилтан, албан хаагчдын албан тушаал, утасны жагсаалт, е-мэйл хаягийг байгууллагын сайтад байршуулсан. Мөн байгууллагын удирдлагууд ажлын өдрүүдэд иргэдтэй уулзах цагийн хуваарийг нээлттэй байршууллаа.
3	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Ажил үйлчилгээний үнийн санал болон холбоотой ажилтнуудын нэр болон утасны жагсаалтыг байгууллагын сайтад байршуулсан болно.
4	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Байгууллагын даргын тушаалыг цаг тухай бүрд нь дотоод самбар болон байгууллагын сайтын холбогдох цэснд нэмэлтээр оруулж байна.
5	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсанд 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах	Нийслэлийн мэдээллийн нэгдсэн сан www.ublegal.mn сайтыг холбогдох дүрэм журмын дагуу хөтөлж 2018 оны А,Б тушаалуудыг файл хэлбэрээр оруулж эхлээд байна. Цаашлаад байгууллага үүссэн цагаас гарсан А,Б тушаалуудыг оруулж, кодификаци хийж ажиллахаар бэлтгэж байна.
6	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Байгууллагын ажил үйлчилгээг сурталчилсан танин мэдэхүйн сэтгүүл 2016, 2017 онд хэвлүүлсэн бөгөөд үйл ажиллагаатай холбоотой брошур танилцуулга, Хүй долоон хугагийн байршлын хөтөч зэргийг хэвлүүлэн тарааж ашиглаж байна.

7	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх	Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ нь НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа тул энэ заалтад хамааралгүй болно.
8	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Манай байгууллага нь ямар нэгэн зөвшөөрөл олгодоггүй болно. Энэ жил Хүй долоон худагт худалдаа болон хөдөлгөөнт тоглоомын үйлчилгээ явуулах тодорхой тооны зөвшөөрөл олгох бөгөөд үүнтэй холбоотой Үндэсний их баяр наадмын тохижилт, худалдаа үйлчилгээний салбар хорооноос ирсэн чиглэл удирдамжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллахаар бэлтгэл ажлаа хангаж байна.
9	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй "Монгол наадам цогцолбор"-ын дэд бүтэц их засварын ажлын тендерийг Нийслэлийн худалдан авалтын газар зохион байгуулж байна. "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын мэдээллийн ил тод байдлын тайланг хавсаргав. 4-р хавсралт/
Хэсгийн дундаж хувь:		

Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал

1	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах	Сул орон тооны зарыг тухай бүр байгууллагын дотоод мэдээллийн самбар болон байгууллагын албан ёсны www.mnts.ub.gov.mn цахим хуудсанд тухай бүр шинэчлэн олон нийтэд нээлттэй ажлын зарыг хүргэж байна. Сул орон тооны зарыг 2019 оны 06 дугаар сарын 15-ны өдөр шинэчлэн Тохжилт үйлчилгээний 2 сул орон тооны зарыг www.mnts.gov.mn цахим хуудсанд шинэчлэн байршуулсан.
2	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/14 дугаар тоот тушаалаар батлагдсан Ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг нийт ажилтан, албан хаагчид өдөр тутамдаа мөрдөн ажиллаж тухайлсан журмыг нээлттэйгээр байгууллагын дотоод мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна.
3	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Байгууллагын цахим хуудас www.mnts.ub.gov.mn -нд хуулиар хориглоогүй мэдээллийг ойлгомжтой байдлаар байршуулсан. Үүнд: 1. Байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр 2. Ажлын байрны нээлттэй зар 3. Байгууллагын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам 4. Байгууллагын бүтэц, зохион байгуулалт 5. Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар. 6. Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт
4	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээлэл зэргийг нээлттэйгээр өдөр тутам шинэчлэн цахим хуудсан байршуулж байна. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр 2017-2020 онд хэрэгжүүлэх “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр” -ийн хүрээнд дараах ажлуудын хэрэгжүүлэн ажилласан. Үүнд: 1. Нийт ажилтан, албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан Нийт ажилтан, албан хаагчдыг сургалтад хамруулсан.

5	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулсан мэдээлж байх	Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.4, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", Байгууллагын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.10.6 дахь заалтуудыг үндэслэн 2019 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн газрын даргын А/08 тоот тушаалаар батлагдсан "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын ажилтан, албан хаагчдад "Ур чадварын нэмэгдэл олгох ажлын хэсэг"-ийг нэгдүгээр хавсралтаар, "Ажилтан, албан хаагчдын ажлын гүйцэтгэл нэмэгдэл олгох журам"-ыг хоёрдугаар хавсралтаар, "Албан хаагчдын ажлын гүйцэтгэл үнэлэх хуудас"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус батлан ур чадварын нэмэгдлийг дээрх журмын дагуу сар бүр дүгнэн ажиллаж байна. Ажилтан албан хаагчдын ажлын үр дүнг сар бүрийн 22-ноос дараа сарын 22-ны хоорондох хугацаагаар үнэлж дүгнэн ур чадварын нэмэгдлийг тооцож олгоно. Ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн албан тушаалын онцлолт нийцсэн таван шалгуур үзүүлэлтээр үнэлнэ. Үүнд: 1. Сар тутмын ажлын төлөвлөгөө, тайлан 2. Цаг ашиглалтын байдал 3. Төрийн албаны ёс зүйг баримтлан ажиллаж байгаа эсэх 4. Удирдлагаас болон шуурхайгаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, өөрийгөө хөгжүүлэх 5. Энэ хэсэгт албан тушаал бүрийн онцлолт тулгуурлан өөрөөр заагдсан.																																			
	Хэсгийн дундаж хувь: Хэрэгжилтийн дундаж хувь:	<table><tr><th>№</th><th>Ур чадварын үндсэн шалгуур үзүүлэлт</th><th>Үнэлгээ</th><th>Оноо</th><th>Тайлбар</th></tr><tr><td>1</td><td>Тухайн сарын ажлын төлөвлөгөө, тайлан</td><td></td><td>5</td><td></td></tr><tr><td>2</td><td>Цаг ашиглалтын байдал</td><td></td><td>5</td><td></td></tr><tr><td>3</td><td>Төрийн албаны ёс зүйг баримтлах, ажиллаж байгаа эсэх</td><td></td><td>5</td><td></td></tr><tr><td>4</td><td>Удирдлагаас болон шуурхайгаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, өөрийгөө хөгжүүлэх</td><td></td><td>5</td><td></td></tr><tr><td>5</td><td>Байгууллагын өмнө тухайн үйл ажиллагааг үндсэн зорилон байгуулах хөдөлгөөн</td><td></td><td>5</td><td></td></tr><tr><td colspan="3">Ерөнхий үнэлгээ</td><td>25</td><td></td></tr></table>	№	Ур чадварын үндсэн шалгуур үзүүлэлт	Үнэлгээ	Оноо	Тайлбар	1	Тухайн сарын ажлын төлөвлөгөө, тайлан		5		2	Цаг ашиглалтын байдал		5		3	Төрийн албаны ёс зүйг баримтлах, ажиллаж байгаа эсэх		5		4	Удирдлагаас болон шуурхайгаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, өөрийгөө хөгжүүлэх		5		5	Байгууллагын өмнө тухайн үйл ажиллагааг үндсэн зорилон байгуулах хөдөлгөөн		5		Ерөнхий үнэлгээ			25	
№	Ур чадварын үндсэн шалгуур үзүүлэлт	Үнэлгээ	Оноо	Тайлбар																																	
1	Тухайн сарын ажлын төлөвлөгөө, тайлан		5																																		
2	Цаг ашиглалтын байдал		5																																		
3	Төрийн албаны ёс зүйг баримтлах, ажиллаж байгаа эсэх		5																																		
4	Удирдлагаас болон шуурхайгаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, өөрийгөө хөгжүүлэх		5																																		
5	Байгууллагын өмнө тухайн үйл ажиллагааг үндсэн зорилон байгуулах хөдөлгөөн		5																																		
Ерөнхий үнэлгээ			25																																		